



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.04.27, БААСАН ~ №086 (885)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Удахгүй баг, гудамж бүр хаалгатай болох шинжтэй

Хөшөө босгох зардалд цэцэрлэгийнхээс тав дахин ихийг төсөвлөжээ. > 3



Бизнес, эдийн засгийн төрөлжсөн сувар Financial Times-ийн нийтлэлүүдийг албан ёсны эрхтэйгээр хүргэж байна.

Эрдсийн салбарын эмзэг байдал төсвийн бодит эрсдэл

Уул уурхайн орлогын 59 хувийг эцс дангаараа бүрдүүлнэ. > 12

ZGM DAILY

Justice Minister embroiled in a scandal of spying on 9 journalists

Prosecutor's office confirms there is an ongoing investigation. > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ирландын Парламентын Доод танхимын дарга даваа гарагт Монголд айлчилна.
Газар өмчлөх хугацааг арван жилээр сунгах хуулийн төслийг УИХ баталлаа.

ЭДИЙН ЗАСАГ

Ипотекийн зээл хүссэн 479 иргэнд 49.5 тэрбум төгрөгийн зээл шинээр олгожээ.
БНСУ-ын экспорт сэргэсэн нь ДНБ энэ оны эхний улиралд 1.1 хувиар өсөхөд нөлөөлжээ.

НИЙГЭМ

Нүүх өргөдөө өгсөн СБД-ийн малтай 50 өрхөд олгох газрыг сугалаагаар тодруулав.
Иргэний интернет банкиг ашиглан залилан хийсэн 50 мянган тохиолдол бүртгэгджээ.

ДЭЛХИЙ

Хойд Солонгосын цөмийн байгууламж эвдэрч нурсан байна.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ҮР ДҮНГҮЙ ЧУУЛГАНУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ЗАЛХААЖ ЭХЛЭВ ҮҮ



Монгол Улсад хөрөнгө оруулалт татах нэг л зорилго бүхий чуулганыг бид янз бүрийн нэршил дор сүүлийн 10 гаруй жил зохион байгуулж ирлээ. Гэтэл эдгээр чуулганы тоо, давтамж нэмэгдэж, бодитой үр дүн нь буурахын хэрээр уг арга хэмжээ нь үнэгүйдэх хандлагатай болж байна. ►11

С.Батсайхан / ЗГМӨ

ОЮУ ТОЛГОЙ МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖЛИЙН ДАРААГИЙН ШАТАНД ХҮРГЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ МӨН

Сүүлийн үед Оюу Толгой төслийн үр өгөөжийг үгүйсгэсэн, нийгэмд эргэлзээ төрүүлэхүйц мэдээллийг зохион байгуулалттай тараах болсонтой холбогдуулан Монголын бизнесийн холбоодын зүгээс олон нийтэд хандан, байр сууриа илэрхийлэх нь зөв гэж үзлээ.

Нэгт, Оюу Толгой төсөл нь Монгол Улсад сүүлийн 25 жилд хийгдсэн хамгийн том гадаадын шууд хөрөнгө оруулалт бөгөөд дэлхийн түүхэнд нэг уурхайд хийсэн хамгийн их дүнтэй хөрөнгө оруулалт болоод зогсохгүй манай улсын гадаад харилцааг гуравдагч хөрштэй холбосон эдийн засгийн бодит тулгуур мөн. Энэ төслийн үр дүнд бид хоёр хөршөөсөө хараат бус байдлаар эрдэс баялгаа арилжааны шударга зарчимд тулгуурлан өндөр үнэд хүргэх боломж бүрдэж байна.

Төслийг хэрэгжүүлэгч, хөрөнгө оруулагч Рио Тинто нь дэлхийн уул уурхайн салбарт тэргүүлэгч бөгөөд Оюу Толгойд шилдэг техник технологио оруулж ирснээр шинэ үр чадвар, туршлага Монголын хөрөнд бууж байгаа юм. Монгол залуучууд дэлхийд үнэлэгдэхүйц үр чадвар, арга туршлагад суралцаж байгаа нь төслийн хөрөнгө оруулалтын үнэлж баршгүй чухал хэсэг мөн.

Харин төслөөс манай эдийн засагт оруулсан шууд хувь нэмрийг тооцвол 2010-2017 оны хооронд нийт 7.2 тэрбум доллар зарцуулж, олон мянган ажлын байр, хэдэн зуун шинэ бизнесийг төрүүлсэн нь татварын суурийг төдий хэмжээнд өргөжүүлж өгснөөс гадна зөвхөн 2017 онд улсын төсөвт дангаараа 180 сая долларыг оруулсан байдаг. Оюу Толгой нь 1,100 гаруй дотоодын ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллаж, жилд 1 тэрбум долларын мөнгөн урсгалыг Монголын зах зээлд нэмэрлэж байна.

Хоёрт, Оюу Толгойн ордон жинхэнэ үнэ цэнэ агуулагдаж буй 1,300 метрийн гүнд орших гүний уурхайн барилга угсралтын ажил ид өрнөж байгаа. Энэ их бүтээн байгуулалтад үндэсний олон компаниуд оролцож мэдлэг чадвар, туршлага хуримтлуулж байгаагаас гадна 14,000 Монгол залуус ажил орлоготой болж, дэлхийд ховор үр чадвар, туршлагыг хуримтлуулсан үнэтэй боловсон хүчин болж бэлтгэгдэж байна.

Дэлхийд танигдсан энэ орд нь 2002 онд анх нээгдсэн ч хэт их үлс төржсөнөөс болж дөнгөж 2009 онд л Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бол 2012-2015 оны хооронд бүтэн гурван жил дахин гасан билээ. Үүний уршгаар Монгол Улсыг сонирхсон олон улсын хөрөнгө оруулагчдыг үргээгээд зогсохгүй дотоодын баялаг бүтээгчдийг гацааж, эдийн засгийн хямралд ард иргэдээ оруулсныг бид ийм амархан мартаж болохгүй. Эндээс хожсон зүйл Монголд, Монголчуудад ганц ч үгүй.

Харин Монгол Улсын Засгийн газартай хийсэн хэлэлцээрийн үр дүнд гүний уурхайн бүтээн байгуулалтыг 2016 онд эхлүүлж эдийн засагт мэдрэгдэхүйц эерэг өөрчлөлт, идэвхжилт харагдаж эхэлснийг манай эдийн засагчид, бизнес эрхлэгчид бэлхнээ гэрчилнэ. Иймээс гүний уурхайн бүтээн байгуулалтыг дуусгаж 2027 оноос бүрэн хүчин чадлаар нь олон улсад өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэлийг бий болгох нь үндэсний эрх ашигт нийцнэ гэж бид үзэж байна.

Гуравт, Оюу Толгой төслийн алдаа оноо, амжилтаас шалтгаалж дараа дараагийн гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх эсэх нь шалтгаалах учир бид асуудалд хүлээцтэй хандаж, төслийг бүрэн хэрэгжүүлэн олон улсын түншүүдтэйгээ нягт хамтран ажиллаж, олон улсын хамтын нийгэмлэг, зах зээлд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын дүрмээр оролцож чаддагаа Монголчууд бид харуулах үүрэгтэй.

Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлж, нэг салбараас хэт хамаарлыг үгүй хийх зорилтын хүрээнд эрдэс баялгийн салбараа дэлхийн жишигт хүргэн хөгжүүлж, түүнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татаж чаддаг болох ёстой.

Эрдэс баялгаараа түүчээлэн хөгжиж чадсан Канад, Австрали, Чили улсуудаас бид суралцаж болох бөгөөд дэлхийн тавцанд олон улсын бизнесийн дүрэмд захирагддаг итгэлцлийн тогтолцоог төлөвшүүлэн бэхжүүлж байж бид цаашид хөгжинэ. Улс орны хөгжил, бидний үр хүүхдийн гэрэл гэгээтэй ирээдүй бидний өнөөдрийн шийдвэр, үйлдэл эс үйлдлээс хамаарна. Хүчээ нэгтгэн урагшаа тэмүүлье!

CEO Клуб
Монголын Бизнесийн Зөвлөл
Улаанбаатар Хотын Худалдааны Танхим
Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
Монголын Барилгын Үндэсний Ассоциаци

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

ТҮҮХЭН ШИЙДВЭР ХАМТДАА ГАРГАЯ

2018|04|28

Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Хөрөнгө Оруулагч Үндэстэн (Жинст Увс) ХК -ийн хувьцаа эзэмшигч нар болон хөрөнгийн зах зээл сонирхож буй бүх хүнд нээлттэй

Ард Санхүүгийн Нэгдлээс гаргаж буй шинэ бүтээгдэхүүний

Ард Базар үзэсгэлэн худалдаа

Гадаад болон дотоодын зочдын

Хурлын үеэр таны хүүхдийг хөгжөөнт тоглоом тоглуулах болон кино үзүүлэх

Хүрэлцээтэй авто машины зогсоол

10:00 цагт

Туушин зочид буудал

info@ardholdings.mn

ardholdings.mn

хөтөч.лугших.бүтээлчид

7707 8181

| АЛТ | ЗЭС | 10-ЧИНГИС БОНД | ХУРАЛДАЙ БОНД | ГЭРЭГЭ БОНД | АМ.ДОЛЛАР | ЮАНЬ | РУБЛЬ |
|------------------|---------------|----------------|-----------------|----------------|-----------|--------|-------|
| 1323.80 0.08% | 7008 0.07% | 96.65 0.09% | 111.05 0.21% | 97.52 0.37% | 2398.64 | 378.64 | 38.13 |

Улс төр

ЕРӨНХИЙЛӨГЧ

Сушма Свараж
Ерөнхийлөгч
Х.Баттулгад
бараалхлаа

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарын урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Гадаад хэргийн сайд Сушма Свараж өчигдөр Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхлаа.

Энэ үеэр хатагтай Сушма Свараж тус улстай хамтран хэрэгжүүлэх гэж байгаа нефть боловсруулах үйлдвэр Монгол Улсын хувьд шатахууны хараат байдлаас гарахад хэчнээн чухал болохыг ойлгож ихээхэн анхаарал хандуулж байгаа хэмээлээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНЭУ-тай түүх, соёл, шашны хувьд хамтын ажиллагаа сайн хөгжиж байгааг онцлоод, цаашдаа эдийн засгийн харилцааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн юм. Мөн БНЭУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарт өөрийнхөө мэндчилгээг дамжуулахыг тус улсын Гадаад хэргийн сайдаас хүслээ. Талууд хоёр улсын хамтын ажиллагааны цаашдын хөгжилд анхаарч, бүхий л салбарт хамтын ажиллагааг үр дүнтэй хөгжүүлэх талаар санал солилцож ярилцав. [ЗГМ]

АЙЛЧЛАЛ

Ирландын
Парламентын
дарга Монголд
айлчилна

УИХ-ын дарга М.Энхболдын урилгаар Ирланд Улсын Парламентын Доод танхимын дарга Шон О'Фарел ирэх даваа гарагаас Монгол Улсад албан ёсны айлчлал хийнэ. Айлчлалын үеэр хоёр орны парламентын дарга нар албан ёсны уулзалт хийж, хоёр талын харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааны болон харилцан сонирхсон бусад асуудлаар санал солилцох аж.

Мөн тэд Монгол Улсын Их Хурал, Ирланд Улсын Парламентын Доод танхим хоорондын хамтын ажиллагааны Санамж бичигт гарын үсэг зурах юм. Айлчлалын хүрээнд ноён Шон О'Фарел Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад бараалхахын зэрэгцээ Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдтэй уулзана. Монгол Улс Ирланд Улстай 1998 дипломат харилцаа тогтоосон. Хоёр улсын харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд түлхэц үзүүлэх энэхүү айлчлал нь хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойн жилд болж байгаа аж. [ЗГМ]

ХЗДХ-ийн сайдын тушаалаар нэр
бүхий есөн сэтгүүлчийг тагнасан гэх
цагдаа нар яллагдагчаар татагджээБ.Сэлэнгэ
ЗГМ

Хууль зүй, Дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн заавраар цагдаагийн байгууллагын зарим албан тушаалтан гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчин, нэр бүхий сэтгүүлчид болон тэдний ар гэрийнхнийг тагнаж, чагнасан тухай асуудал үүслээ.

Тодруулбал Хууль зүй, Дотоод хэргийн сайд Ц.Нямдорж уг албан тушаалд очсоныхоо дараа ЦЕГ болон ЭЦА-ны удирдлагад үүрэг өгч, нэр бүхий есөн сэтгүүлч, тэдний ар гэрийн 30 хүний мэдээллийг хууль бусаар олж аван тагнасан талаар эх сурвалжууд мэдээлж эхэллээ. Түүгээр зогсохгүй нэг сэтгүүлчийн автомашин руу буудан айлгасан байна. Гүйцэтгэх ажлын тухай мэдээ, тайлангаа ЭЦА-наас Тагнуулын Ерөнхий газарт өгдөг аж. Тэр тайлан дунд сэтгүүлчдийн тухай мэдээлэл байсныг тагнуулынхан шалгаснаар энэ хэрэг илэрсэн юм.

Харин сайд Ц.Нямдорж өөрөө уг асуудлыг үгүйсгэв. Тэгэхдээ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэтгүүлчийн автомашин руу буудсан хэмээн мэдээлэгдсэн асуудлыг дугуй руу нь хэмээн тодотгосон юм. Сэтгүүлчдэд мэдээлэл хийх үеэрээ, хэд хэдэн асуудалд олон нийтэд хэдийнэ ил болсон мэдээллийг дэлгэрүүлж, энэ асуудлаар илүү мэдээлэлтэй байсан нь илүүтэй анхаарал татсан юм.

Улмаар М.Зэнэ, О.Дашбалбар, С.Зориг нарын амьдралын сүүлийн жилүүдэд тохиосон үйл явдлуудыг эш татаад, өөрийгөө тэдгээр хүмүүстэй зүйрлэн яриу. Гэвч Хууль зүй, Дотоод хэргийн сайд Ц.Нямдоржтой холбоотой хэргийг Нийслэлийн прокуратурын



байгууллага үгүйсгэсэнгүй. Бүр уг асуудалд холбогдсон цагдаагийн байгууллагын алба хаагчдад эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг Тагнуулын ерөнхий газраас прокуратур ирүүлсэн байна.

Нийслэлийн прокуратурын газрын олон нийттэй харилцах ажил хариуцсан хяналтын прокурор Г.Баясман "Энэ асуудлыг ТЕГ-ын мөрдөн шалгах хэлтэсээ шалгаж, холбогдох албан тушаалтнуудад эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал гаргаж, Прокуратурын хяналтад ирүүлсэн. Прокуратураас энэ асуудал дээр хэргийг хянаж байна" гэв. Монголын төрийн түүхэнд улстөрчидтэй холбоотой тагнаж, чагнасан асуудлууд нэг бус удаа гарч байсан. Сануулахад 1992-1996

оны П.Жасрайн Засгийн газрын үед багш нарыг тагнасан хэрэг мандаж байлаа. Энэ үед Ц.Нямдорж Их хурлын гишүүн байсан. Мөн 1997 оны сүүлчээ тухайн үеийн МАН-ын дарга Н.Энхбаяр, Ерөнхий сайд П.Жасрай нарыг мөн тагнаж чагнасан гэх дуулиан гарч байв. Энэ талаар МАН-ын Удирдах зөвлөлөөр хэлэлцэн, Ц.Нямдоржид уг асуудлыг УИХ-д хэлж үүнийг өгсөн байдаг. Харин үүнээс нэлээн хожуу буюу 2003 онд сайд Ц.Нямдоржийг БНХАУ-ын тагнуул гэх асуудлыг УИХ-ын гишүүн Л.Гундалай олон нийтийн өмнө гарган тавьсан юм. 1990 оны эхээс Ц.Нямдорж хятадын тагнуулын албаны ажилтнуудтай холбогдох болсон, тэднээс бэлгэ сэлт авч, үе үе Бээжин нисдэг байсан тухай Тагнуулын газрын



С.Батсайхан /ЗГМ

нууц материал 2000 оны эхээр олон нийтэд ил болж, тэр цагаас хойш өөрийнхөө буруугүйг нотлох гэсэн Ц.Нямдорж, хэрэг явдлыг шалгуулахыг хүссэн генерал Ж.Баатарын хооронд хүчтэй тэмцэл өрнөж байсныг монголчууд санаж байгаа. Гэвч генерал Ж.Баатар улсын нууц задруулсан хэрэгээр шоронд хоригдсоноор хэрэг хаагдсан гэхэд болно. Харин Ж.Баатар генерал "Ц.Нямдоржийг Хятадын тагнуултай уулзаж байсныг харсан гэрчүүд байдаг. Мөн түүнийг гэрчлэх гэрэл зураг ч бий. Гэвч энэ баримтыг шүүх хурал авч хэлэлцээгүй" хэмээн ярьсан байдаг юм.

Мөн 2000 онд Ардчилсан намын байрнаас цагнах төхөөрөмж олдлоо гэх дуулиан дэгдэн, тухайн үеийн АН-ын дарга Д.Дорлигжав

энэ талаар хэвлэлийнхэнд мэдэгдэж байлаа. Харин энэ үед Ц.Нямдорж Хууль зүй, Дотоод хэргийн сайд байсан юм.

2017 онд Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг тагнасан, мөрдөж мөшгисөн хэрэг гарсан. Тухайн үед У.Хүрэлсүх Шадаар сайд байсан бол, Ц.Нямдорж нь УИХ-ын дэд дарга байлаа. Харин өнөөдөр Хууль зүй, Дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн заавраар сэтгүүлчид болон тэдний гэр бүлийг тагнаж, чагнасан дуулиан дэгдэж байгаа нь энэ юм. Ингэснээрээ сайд Ц.Нямдоржийг эдгээр бүх үйл явдалтай холбоотой гэсэнгүй. Гэхдээ Монголын тагнаж, чагнахтай холбоотой асуудалд тэрбээр анх удаа нэр холбогдож байгаа хэрэг биш гэдэг нь харгалдаж байна. [ЗГМ]

Газар өмчлөх хугацааг арван жилээр сунгалаа

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг УИХ-ын чуулганаар хэлэлцэж байгаагаар холбогдуулан нийслэлийн ундны усны үзүүсэр болсон Туул голын ай савын дагуух барилга, объектуудын асуудлыг гишүүд хөндөж байв. Барилга байгууламжаас гадна түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож байгааг УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан тус хуулийн төслийг боловруулсан

Ажлын хэсгийнхнээс асуулаа.

Агаар, орчны бохирдол хүндэрсэн өнөөгийн нөхцөлд Улаанбаатарын дагуу хотуудыг байгуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгамдаад байгааг тэрбээр мөн сануулав.

Яармагийн гүүрнээс Баян-зүрхийн товчоо орох чиглэлийн дагуу Туул голын урд хэсэг нь тусгай хамгаалалттай газар аж. Энэ бүсэд аялал жуулчлалын зориулалтаар 50 гаруй иргэн, аж ахуйн нэгжид үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгосон байдаг юм байна.

БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ч.Галын хэлснээр дээрхээс 28 иргэн, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг энэ оны нэгдүгээр улиралд цуцалжээ. Мөн хүрээлэн буй орчинд эрсдэл үүсгэдэг буй 28 тусгай зөвшөөрлийг цуцлахаар ажиллаж байгаа гэв.

Түүнээс гадна Туул голын дагуух аялал жуулчлалын бүс байгуулах төлөвлөлтийн дагуу тодорхой ажлууд хийгдэж байгаа аж. Газар өмчлөлтэй холбогдуулан гишүүдийн хөндсөн дараагийн асуудал нь гэр

бүлийн хэрэгцээний зориулалтаар Монгол Улсын иргэнд газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлэх хугацаа заахгүй байхыг гишүүд хэлж байв. Өөрөөр хэлбэл газар өмчлөлийн хуулийг 2028 он хүртэл сунгахаар тусгасан байгааг өөрчилж, хугацаагүй болгох санал юм.

Гэвч газрын харилцаа, газар хувьчлалын асуудлыг бодлогын түвшинд иж бүрнээр нь зохицуулах нь зүйтэй гэж Ажлын хэсгийн ахлагч Г.Тэмүүлэн гишүүн хариуллаа.

Төвлөрсөн дэд бүтэц бүхий суурин газруудад иргэд гэр

бүлийн хэрэгцээний зориулалттай газар өмчлөх сонирхолтой байгаа. Гэвч газар хүрэлцээгүй байгаа. Тиймээс төр үүн дээр анхаарал хандуулж, нийслэлийн төвлөрлийг сааруулах чиглэлээр дагуу хотуудыг байгуулах, шаардлагатай бол тодорхой аж ахуйн нэгжүүд, төр захиргааны байгууллагуудыг шилжүүлэх зэрэг шийдвэртэй алхамуудыг хийх нь зүйтэй гэдэг байр суурийг Д.Оюунхорол гишүүн илэрхийлсэн. Ийнхүү хэлэлцээний эцэст Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг олонхийн саналаар баталлаа. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.04.27

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Удирдлагын нэгдсэн төвийн барилгын гадна цахилгааны шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэчийг сонгон шалгаруулах.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-АУ-2018-86

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос Удирдлагын нэгдсэн төвийн барилгын гадна цахилгааны шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

-Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

-Сүүлийн 2 жилд буюу 2016, 2017 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ. -Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2016, 2017/ тус бүр тухайн ажлын төсөвт өртөгөөс дээш байх.

-Тендерийн хамт 7,600,000 /долоон сая зургаан зуун мянган/ төгрөгний тендерийн баталгаа ирүүлнэ.

-Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийг дуустал.

Тендерийг 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-223

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.04.27

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Ус сувгийн удирдах газарт бага оврын автобус /микробус/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР: УСУГ-ХА-2018-121

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос бага оврын автобус /микробус/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендер эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

-Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

-Сүүлийн 2 жилд буюу 2016, 2017 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.

-Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2016, 2017/ тус бүр тухайн барааны төсөвт өртөгөөс дээш байх.

-Тендерийн хамт 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгний тендерийн баталгаа ирүүлнэ.

-Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийг дуустал.

Тендерийг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 14 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 14 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-223

Нийтлэлчийн булан



Удахгүй баг, гудамж бүр хаалгатай болох шинжтэй



Хөшөө босгох зардалд цэцэрлэгийнхээс тав дахин ихийг төсөвлөжээ

З.Цэлмэг
@tselmegZGM

Та Парист очоогүй ч байж болно. Гэхдээ Францын эзэн хаан Наполеон Бонапартын аугаа ялалтын гэрч болж үлдсэн Ялалтын хаалга буюу Arc de Triomphe-ийн тухай мэдэхгүй хүн байдаггүй. Харин Францыг анх удаа зорих гэж буй хэн нэгэнд бол хэнтэй ч яриа өгөж болохоор өргөн сэдэв. XIV Луи хаанаас хойш Франц орныг дахин агуу болгосон Наполеон хааны сүр хүчийг бэлгэддэг, архитектурын сод бүтээл учраас яах аргагүй хүн төрөлхтний аугаа бүтээн байгуулалтын нэгд тооцогддог билээ.

Ялалтын хаалгатай төстэй дэлхийн бусад бүтээн байгуулалтын ихэнх нь дайн байлдааны ялалт, цэрэг армийн сүр жавхланг илтгэдэг. Түүхийг урагшлуулбал, 1791 онд барьж дуусгасан Бранденбургийн хаалга, Иерусалемийн Нийгүүлслийн алтан хаалга, эртний Вавилоны үеийн Иштар хаалга гээд үеийн үед цэргийн сүр хүчээр ноёрхлоо тогтоосон эзэнт гүрнүүдийн бүтээн байгуулалт энэ цаг үед үлдсэн урлагийн юм шиг түүхэн бүтээл болдог.

Эдгээр дурсгал өнөө цагт ч ач холбогдлоо алдаагүй, эдийн засгийн үр өгөөж өгсөөр байгаа нь тухайн үедээ асар их хөрөнгө мөнгө, цаг хугацаа, хүчээр байгуулсны гавьяа, ухаалаг удирдагчийн шийдвэр гэмээр. Угаасаа ч хүн төрөлхтний шинжлэх ухааны хөгжил, технологийн ололт дэвшил ийм хэмжээний бүтээн байгуулалт хийх түвшинд байсан нь тэр.

Харин цаг үе, хөгжил дэвшилээ дагаад улс орнуудын бүтээн байгуулалт өөр болсон. Далай дээр байшин барихаас эхлээд амьд байгалийн цэцэрлэгт хүрээлэн, сансар огторгуйд эсвэл бүр молекул, генетикийн түвшинд ямар нэгэн бүтээн байгуулалт хийдэг болсон нь ухаант хүмүүний гайхамшиг үргэлжилж буйн илрэл.

Гэтэл Монголд энэ хөгжил хэдэн арав биш бүр хэдэн зуунаар хоцорч явна. Бүтээн байгуулалтын талаарх монголчуудын өнөөгийн ойлголтыг дэлхийн дундажтай харьцуулахад ганц миний урам хугарахгүй байх. Өнөөдөр аймаг, сум бүрийн төвд дээдлэн босгосон хаалгыг одоо мэдэгдэж байгаагаар хамгийн эрт үед босгосон хаалгатай харьцуулаад төсөөлье. Та ар дагзруугаа тоосгоор гөвүүлсэн мэт дотор харанхуйлж байвал

таны төсөөлөн бодох чадвар тун оновчтой юм. Хүн төрөлхтөн харанхуй бүүдүүлэг үеэсээ салаад удаагүй байхдаа ч шавар, чулууг урлагтай эвлүүлдэг байсны ул мөр одоо ч бий.

Хамгийн харамсалтай нь, олон сая төгрөг зарцуулж босгосон эдгээр хаалгаа монголчууд бүтээн байгуулалт, хөгжлийн илрэл гэж ойлгодог нь ой гутааж байна. Нэлээд хэд хоногийн өмнө нийгмийн сүлжээнд “Нэг аймагт уул уурхайгаас 500 гаруй сая төгрөгийн орлого ортол 100 гаруй саяар нь уулын орой дээр завилсан бурхан барина гэх юм” гэсэн бухимдал нэлээд тархсан. Үүнээс төд удалгүй хэд хэдэн сумын төвд босгосон хүндэтгэлийн хаалга олны бухимдлыг төрүүлсэн юм. Орон нутагтаа цэцэрлэг, сургууль барих, засварлах мөнгө байхгүй гээд төсөв харж хоосон суудаг атлаа орон нутгийн хөгжлийн сангаас тоосгон хаалга, шавар суварга гэх мэтэд өчнөөн арван саяыг хайр найргүй зарцуулж байна. Хэд хэдэн аймаг, сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч гэх мөнгөөр туйлагчид төсөвлөсөн мөнгөө эрхэн зарцуулдгийг нь сонирхлоо.

● **Олон сая төгрөг зарцуулж босгосон эдгээр хаалгаа монголчууд бүтээн байгуулалт, хөгжлийн илрэл гэж ойлгодог нь харамсалтай.**

● **Манай хүнгүй шахам сумын хэмжээний жижиг засаг захиргааны нэгж нь хил заагаа замын тэмдэглэгээ, жижиг самбараар л тэмдэглэдэг жишиг олон улсад бий.**

● **Дарьганга, Сайншанд, Хужирт гээд амбийцтай нутгуудын хаалга гантг чулуутай, уран сийлбэртэй тул зардал нь 100 саяас буухгүй шүү.**

Хөвсгөл аймгийн Мөрөн суманд энэ жил 100 хүүхдийн нэг цэцэрлэг барих шаардлагатай байгаа аж. Зардал нь 1.1 тэрбум төгрөг. Гэтэл цэцэрлэгийн барилгын ажилд энэ онд улсаас ердөө 141 сая төгрөг л төсөвлөсөн байна. Өөрөөр хэлбэл, энэ жил цэцэрлэг барих ажил 10 гаруй хувьтай байна гэсэн үг. Энэ

эрчээрээ бол 10 жилийн дараа л нэг цэцэрлэгтэй болох нь. Тэгвэл Орон нутгийн хөгжлийн сангаас Алаг-Эрдэнэ суманд босгох “50, 100 энергийн төв”-ийн бүтээн байгуулалтад 765 сая төгрөг төсөвлөсөн гээд боддоо. Жуулчид татах зорилгоор барьж буй энэ цогцолборын нийт өртөг тэрбум гаруй төгрөг бөгөөд дэлхийд ховорт тооцогдох энергийн энэ төвд хүмүүс шинийн 1-ний өглөөний нар харж, хийморио сэргээхээр ирдэг болоод уджээ. Харин баяр наадмын талбайн их засварт 199 сая төгрөг зарцуулахаар болжээ. Ер нь сумын төвийн угтах хаалгыг хамгийн багадаа 30 орчим сая төгрөгөөр босгодог.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын хүндэтгэлийн хаалганы зардал 29.8 сая, Өвөрхангайн Тарагт, Дундговь аймгийн Дэлгэрхангай сумынх тус бүр 30 орчим сая төгрөгт боссон. Харин Дарьганга, Сайншанд, Хужирт гээд амбийцтай нутгуудынх бүр гантг чулуутай, уран сийлбэртэй гээд 100 саяас буухгүй шүү. Тэгвэл Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгө зөвхөн хаалганд биш суварга, бунхан гээд үр ашиггүй, үзэж харж, нүд баясгах юмгүй барималуудад үрэгдэх нь их. Энэ чигээрээ явсаар байвал удахгүй багийн, гудамжны гэх мэт энд тэндгүй баахан сүртэй хаалгатай болох шинжтэй.

Гэхдээ орон нутагт хүнд хэрэгтэй бүтээн байгуулалт бий. Гудамжны гэрэлтүүлэг, тохижилт, зам, цэцэрлэг, сургууль, соёл амралтын төв босгох, дээвэр туургыг нь янзлах ажлууд өрнөдөг. Даанч энэ бүхнийг бүтээн байгуулалт гэж хэлэхэд үнэхээр учир дутагдалтай.

Аливаа ажил оршин суугчдын хэрэгцээг хангасан, амьдрал ахуйд нь нэмэртэй байвал бүтээн байгуулалт гэж ойлгож болохоор. Өөрөөр хэлбэл, ажлын байр нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээсэн, ямар нэгэн тулгамдсан асуудал шийдэхэд чиглэсэн байх хэрэгтэй. Хэрэв үгүй бол үргүй зардал гэж нэрлэдэг. Ийм үргүй зардлын тодоос тод жишээ бол Баянзүрх дүүргийн тэрбум шахам төгрөгөөр боссон банхрын хөшөө. Хөшөөний автор нь олон нийтийн эсэргүүцлээс айсандаа хөшөөний ачаар дүүргэгт гэмт хэрэг гарах нь багассан гэж хэлээд доог тохуу болсон.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс аймгуудын өрсөлдөх чадварыг хоёр жил тутамд үнэлдэг. Энэ үнэлгээгээр аймгуудын хамгийн тулгамдсан асуудлын тоонд ажлын байр нэмэгдүүлэх, бизнесийн орчныг дэмжих, хөрөнгө оруулалт татах, хог хаягдал гэх мэт нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, боловсон хүчнээ бодлогоор дэмжиж, төрийн хүнд суртлыг арилгах гэж онцолсон байдаг. Түүнээс биш хэн ч хөшөө босгож, суварга бариад өгвөл

амьдрал сайжрах гээд байна гэж нэхдэггүй.

Шинжлэх ухаанчаар ханддаг болсон цагт л бүтээн байгуулалтыг гадарладаг болно

Дэлхийн томоохон хотууд, түүхт газрууд л түүхэнд үлдсэн чухал үйл явдлыг тодотгож

иймэрхүү бүтээн байгуулалт хийдэг юм. Түүнээс биш манай хүнгүй шахам сумын хэмжээний жижиг засаг захиргааны нэгж нь хил заагаа замын тэмдэглэгээ, жижиг самбараар л тэмдэглэдэг жишиг олон улсад бий. Энэ бүх ялгаа дэлхийн хөгжлөөс дэндүү хоцрогдсон бидний сэтгэлгээнд буйгаас гадна идэж уухын донтой холбоотой гэдгийг бүгд мэддэг. Гэвч эрхтэн дархтанууд уралдан идэж, хулгайлж буй цаг үед энэ үйлдлийн эсрэг дугараад ч нэмэр үгүй буй за.

Уул овоо бол тектоник хөдөлгөөний үр дүнд бий болсон газар зүйн тогтоц болохоос

биш хийморио сэргээнэ гэх нэрийдлээр сүү, сархад, хэвийн боовыг хог мэт овоолдог цэг биш. Мөн наадамд түрүүлсэн морь, үзүүр түрүү булаалдсан бөхийн хөлс нь хөдөлгөөний үр дүнд хуримтлагдсан энерги гадагшилж буй хэлбэр гэдгийг ухаанаа алдах шахам мухар сүсэглэдэг нөхдөд зөвлөмөөр. Монголчууд бид хөдөө явах замдаа хөшөө суварга биш ядаж боловсон жорлон барьж, аливаад шинжлэх ухаанчаар ханддаг болсон цагтаа л жинхэнэ бүтээн байгуулалтын утга учрыг гадарладаг болох биз. Тэр цаг үе хол биш байгаасай. [ВГМ]

Absolute

School of English

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ АЖИЛД АВНА.

“Ажлын байранд тавигдах шаардлага”

- Англи хэлний багшийн мэргэжлээр төгссөн болон төгсөх гэж байгаа.
- Мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- TOEFL & IELTS-н оноотой бол давуу тал болно.

+ Ажиллах таатай орчин

+ Үр дүнгийн нэмэлт урамшуулал

+ Өрсөлдөхүйц цалин

WWW.ABSOLUTE.MN

Холбоо барих : 7711-8288

Нийгэм



Б.Хасуй / ЗГМ©

Сэлбэ голыг сэргээн тохижуулах ажлыг эрчимжүүлнэ

Голын эрэг дагуу олгосон зарим газрыг чөлөөлөх асуудал яригдаж байна

М.Мөнхзүл
@munkhzulZGM

Найман жилийн тэртээ Сүхбаатар дүүргийн удирдлагууд санаачлан Улаанбаатар хотын дундуур урсдаг Сэлбэ голын урсацыг сайжруулах төсөл хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Энэ төслийн хүрээнд усан сан байгуулж, ойр орчимд нь ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн бий болгох байв. Улмаар 100 айлын гүүрнээс урагш АНУ-ын ЭСЯ-ны урд талын гүүр хүртэл тохижилтын ажил хийсэн. Гэхдээ төслийн хэрэгжилт төсөөлсөн хэмжээнд хүрээгүй нь үнэн. Хэсэгхэн зурвас газрыг хальт тохижуулсан болоод нөгөө хэсгийг нь зөнд нь орхисон дүр зурагтай олон оныг үдлээ.

Харин хотын одоогийн удирдлагууд Сэлбэ голын хувь заяанд

дахин анхаарч, тохижилтын ажил эхлүүлэхээр 2017 онд зураг төслийг нь баталсан. Улмаар урин дулаан цаг ирэхтэй зэрэгцэн Сэлбэ голын МУБИС орчмын хэсэгт гүүр барихаар газар шорооны ажилдаа оржээ. Мөн Арслантай гүүрнээс урагш Натур төвийн урд талын гүүр хүртэлх хэсэгт тохижилтын ажил хийхээр төлөвлөдөг байна. Хөрөнгө санхүү нь шийдэгдсэн гэнэ.

Энд хийгдэж буй ажил болон төслийн хүрээнд хийгдэх зүйлийн талаар албаны хүмүүсээс тодрууллаа.

Нийслэлийн зураг төслийн хүрээлэнгийн газрын ерөнхий инженер Ж.Баясгалан “1400 метр зайд боомт бүхий тунгаагуур, үүнээс цааш Нарны зам хүртэл тохижилт болон усны барилга байгууламжийн ажлын зураг хийгдсэн байгаа. Төсөв мөнгө нь ойролцоогоор 50 гаруй тэрбум төгрөг болсон. Үүнд Улаанбаатар хотоор урсаж буй Туул, Сэлбэ голын бүхий л хэсэг багтсан” гэсэн хариулт өглөө.

Харин нийслэлийн Байгаль орчны газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Дамбасүрэн “Энэ жил Сэлбэ голын хүрээнд булгийн эхийг тохижуулж, хамгаална. Тиймээс

хоёр мянган га газрыг орон нутгийн тусгай хамгаалтад авсан. Тэр орчимд явган хүний аюулгүй байдлыг хангаж, тохижуулах зорилготой ажиллаж байна” гэв.

Арслантай гүүрнээс Натур төвийн гүүр хүртэлх хэсгийг тохижуулна

Сэлбэ голын урсацыг нэмэгдүүлж, орчныг сайжруулахын тулд голын эх болон ойр орчмын цутгал гол, булаг шандуудыг 2003 оноос хамгаалж ирсэн. Одоогоор Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт тав, Сүхбаатар дүүргийн нутагт найман булаг, шандыг хамгаалалтад авчээ. Мөн 2016 онд онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд амьдарч буй айл өрхийн судалгааг хийсэн. Судалгаан дээр үндэслэлд зарим хэсгийг чөлөөлөх асуудал яригдах юм байна. Энэ жил үүнээс гадна Дарь-Эхийн Ганц худгийн харалдаа тусгай шүүлтүүр бүхий тунгаагуур хийхээр төлөвлөсөн

байна. Нийслэл хөрөнгө гарган тохижуулалт хийсэн ч тухайн газарт нь хог хаягдал хуримтлагддаг. Харин тунгаагуур хийснээр дээрээс урсаж ирсэн хог хаягдлыг шүүж, хотын төв рүү цэвэр ус урсаж юм.

Хотын өнгө үзэмжийг сайжруулах байгууламж гундааж байсан Сэлбэ голыг сэргээж тохижуулах ажил дахин хийгдэж эхэлсэн нь сайшаалтай. Гэхдээ төслийн хүрээнд яг хэдэн төгрөгийн ажил хийгдэх, энэ мөнгийг хаанаас хэрхэн гаргах нь тодорхойгүй байна. Холбогдох байгууллагууд үүнд анхаарлаа хандуулж урин дулааны цагт ажлаа амжуулаад авбал сайнсан. [ЗГМ]

ОРОН НУТАГ

» ХӨВСГӨЛ

Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны “Хүслийн хад” гэдэг газар Хөвсгөл нуурын мөсөн дээгүүр явж байсан зургаан зорчигчтой автомашин лхагва нуурын усанд осолдлоо. Зорчигчдын хоёр нь амьд гарч, дөрвөн иргэн амь насаа алджээ. Аврагчид осолдсон иргэдийн цогцсыг нуурын эргээс 1300 метрийн зайд, 15 метрийн гүнээс гарган авчээ.

Чандмань-Өндөр сумын Улаан-Асга багийн “Асганы хөндий” гэдэг газарт гарсан ойн түймэр 15 га газрыг хамраад байна. Түймрийн голомтод 110 гаруй иргэн ажиллаж байгаа ч унтрахгүй байгаа юм.

» ГОВЬ-АЛТАЙ

Аймгийн төв Есөнбулаг сумын ЗДТГ-аас 600 иргэнд газар өмчлүүлэхээр төлөвлөгөөндөө оруулсан ч газар эзэмших хүсэлтэй 2000 гаруй иргэн хандаад байгаа аж. Тиймээс сумын удирдлагууд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран ажлын хэсэг байгуулж, тодорхой ажлуудыг үе шаттай зохион байгуулахаар болжээ.

Есөнбулаг сумын Сум хөгжүүлэх сангийн сүүлийн гурван жилийн зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүйн улмаас 2018 он гарсаар нэг ч үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зээл олгогдоогүй байна. Одоогоор зээлийн эргэн төлөлт 20 гаруй хувьтай явагдаж байгаа ба зээлийн нийт өр 800 гаруй сая төгрөгт хүрчээ. Тус сумын ЗДТГ-ын зүгээс гэрээнд заасан хугацаандаа төлбөрөө төлөөгүй 300 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг аймгийн ШШГА-нд шилжүүлж, хуулийн дагуу өр төлбөрийг нь барагдуулах арга хэмжээ авч эхэлжээ.

» БАЯН-ӨЛГИЙ

Аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржаны урилгаар Казахстан улсын Хойд Казахстан мужийн Уалиханов дүүргийн Засаг дарга М.Оспанов тэргүүтэй төлөөлөгчид Өлгий хотод ажиллаж байна. Тэрбээр өчигдөр Өлгий сумын иргэдийн төлөөлөлтэй уулзаж, тухайн мэдээлэл өгөв. Түүний аймгаас ажиллах хүч авах болон шаардлагатай байгаа боловсон хүчний талаар танилцууллаа. Мөн Казахстанд нүүж очих иргэдэд үзүүлэх тусламж, дэмжлэгийн тухай мэдээлэл өгөв. Түүний тайлбарласнаар Уалихан дүүрэгт эмч, сувилагч, англи хэл, хөгжим, мэдээлэл зүй, математик, хими, сэтгэл зүйн багш, малчин, тракторчин зэрэг мэргэжилтэй хүмүүс хомс байгаа аж.

Үйлчилгээний салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг баталлаа

Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, нэгдсэн стандартад оруулах зорилготой дэд хөтөлбөрийг НИТХ-аар баталлаа. “Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ-2020” дэд хөтөлбөр 2020 он хүртэл хэрэгжинэ. Энэхүү хөтөлбөрт нийт 365 сая

төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Энэ хугацаанд худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын стандартыг шинэчилж, гарааны бизнесийг дэмжих зөвлөх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах аж. Улсын хэмжээнд тус салбарт 70 гаруй мянган аж

ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлд 34.5 мянга нь ажиллаж байна. 1990 оноос хойш худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын бодлого алдагдаж, мэргэжлийн боловсон хүчний хомсдолд орсон гэдгийг мэргэжилтнүүд хэллээ. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018.04.27

Тендер шалгаруулалтын нэр: Ус сувгийн удирдах газарт бага оврын усны автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар/гэрээний дугаар: УСУГ-ХА-2018-122

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос бага оврын усны автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгийн цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 жилд буюу 2016, 2017 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2016, 2017/ тус бүр тухайн барааны төсөвт өртөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 3,800,000 /гурван сая найман зуун мянган/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийг дуустал.

Тендерийг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 15 цаг 00 минутаас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 15 цаг 30 минут-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, Р.Батсүрэн Утас: 70157018-223

| 2018/03/31 | | 2018/03/31 | |
|---|---------------------------|--|-----------------------------|
| Балансын зүйл | Эцсийн үлдэгдэл /мян.төг/ | Орлого, зардлын зүйл | Тайлант үеийн дүн /мян.төг/ |
| ХӨРӨНГӨ | | Хүүгийн орлого | 161,862,851 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 1,626,236,496 | Монголбанкинд байршуулсан хөрөнгө | 2,185,341 |
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | 304,037,978 | Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | 1,220,592 |
| Хөрөнгө оруулалт | 1,440,955,951 | Үнэт цаасны | 66,531,450 |
| Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт | 32,821,712 | Зээлийн | 91,925,468 |
| Зээл (цэвэр дүнгээр) | 2,993,210,825 | Бусад хүүгийн орлого | - |
| Хэвийн зээл | 2,888,570,460 | Хүүгийн зардал | 115,865,154 |
| Чанаргүй зээл | 220,133,991 | Харилцахад төлсөн хүү | 8,660,042 |
| Зээлийн хойшлогдсон төлбөр | - | Хадгаламжинд төлсөн хүү | 51,903,945 |
| Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 149,482,508 | Зээлийн хүүгийн зардал | 16,761,397 |
| Зээлийн эрсдэлийн сан | (264,976,134) | Үнэт цаасны хүүгийн зардал | 37,647,645 |
| Дериватив санхүүгийн хөрөнгө | 287,365,494 | Бусад хүүгийн зардал | 892,129 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 11,260,074 | Хүүгийн цэвэр орлого | 45,997,697 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 35,380,303 | Эрсдэлийн сангийн зардал | 3,490,875 |
| Үндсэн хөрөнгө | 323,796,910 | Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого | 42,506,822 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 91,951,413 | Бусад орлого | 143,377,235 |
| Борлуулах зориулалттай хөрөнгө | - | Хүүгийн бус орлого | 143,313,176 |
| Биет бус хөрөнгө | 2,261,571 | Арилжааны орлого | 7,313,874 |
| Нийт хөрөнгийн дүн | 7,116,457,015 | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого | 118,915,027 |
| ӨР ТӨЛБӨР | | Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 10,304,995 |
| Харилцах | 1,303,438,088 | Бусад хүүгийн бус орлого | 6,779,280 |
| Хадгаламж | 1,815,751,975 | Бусад орлого, олз | 64,059 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 1,415,218,729 | Бусад зардал | 148,997,446 |
| Бусад эх үүсвэр | 1,663,297,620 | Хүүгийн бус зардал | 148,660,359 |
| Бусад өр төлбөр | 49,749,789 | Бусад эрсдэлийн сангийн зардал | 582,021 |
| Нийт өр төлбөрийн дүн | 6,247,456,199 | Арилжааны зардал | 6,098,343 |
| ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | | Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал | 119,635,986 |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 50,000,011 | Хураамж, шимтгэлийн зардал | 3,032,938 |
| Нэмж төлөгдсөн капитал | 19,272,456 | Үйл ажиллагааны бусад зардал | 19,311,071 |
| Халаасны хувьцаа | - | Бусад зардал, гарз | 337,087 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 130,014,323 | Татварын өмнөх ашиг, алдагдал | 36,886,611 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 594,753,920 | Орлогын татварын зардал | 1,507 |
| Бусад өөрийн хөрөнгө | 74,960,106 | Татварын дараах ашиг, алдагдал | 36,885,103 |
| Өөрийн хөрөнгийн дүн | 869,000,816 | Бусад орлого | (11,628,235) |
| Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн | 7,116,457,015 | Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн | 25,256,868 |
| Тэнцлийн гадуурх данс | | | |
| Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр) | 658,404,203 | | |

| Зохиистой харьцааны шалгуур үзүүлэлт | Байвал зохих | 03/31/2018 |
|---|--------------|------------|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохиистой харьцаа | >9% | 13.43% |
| Өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа | >14% | 16.25% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт | >25% | 46.80% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) | <+/-15% | -14.37% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) | <+/-40% | -33.93% |

Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд) - д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайлан

| Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд) | Активын хэлбэр | Үлдэгдэл дүн /мян.төг/ | Өөрийн хөрөнгөд эзлэх хувь |
|--|----------------|------------------------|----------------------------|
| Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд) - д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй) | | | |
| Банкны хувьцаа эзэмшигч | Зээл | 332,080.0 | 0.04% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | Зээл | 467140.0 | 0.05% |
| Банкны бусад холбогдох этгээд | Зээл | 2,164,220.0 | 0.25% |
| Банкны холбогдох нийт этгээд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд) - д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй) | | | |
| Банкны хувьцаа эзэмшигчид | Зээл | 913,020.0 | 0.10% |
| Банкны эрх бүхий албан тушаалтанууд | Зээл | 8,917,260.0 | 1.03% |
| Банкны бусад холбогдох этгээд | Зээл | 4,669,380.0 | 0.54% |

ДЭЛХИЙГ ТАНТАЙ ХОЛБОХ САНХҮҮГИЙН ГҮҮР

Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 19, Улаанбаатар хот 14210, Монгол улс
 Утас: 1900-1977 | Факс: 70161988 | И-мэйл: info@tdbm.mn | Вэб хаяг: www.tdbm.mn
 Фэйсбүүк: www.tdbm.mn/facebook | Твиттер: www.tdbm.mn/twitter

ZGM DAILY

Media outlets report Justice Minister order to spy on 9 journalists

The case is currently under investigation of the prosecutor's authority, says GPO.

President meets Indian Foreign Minister

Indian FM highlights India is giving importance to the Joint Project on Oil Refinery.

MIAT Airlines performs first test-flight of Khushigt Valley Airport

MIAT is expected to prepare the test procedures and submit to Civil Aviation Authority.

BDSec JSC holds its shareholders' meeting

The board decides not to distribute dividends as the company is requiring more investment.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

At the invitation of the Mongolian Parliament Speaker Enkhbold Miyegombo, Sean O Fearghail, Speaker of Lower House of Irish Parliament will pay an official visit to Mongolia between April 29 and May 1.

Security organization of Mongolia and Russia holds consultative meeting in Moscow and discussed cooperation opportunities in the fields of security, defence and law enforcement.

Deputy Prime Minister of Mongolia Enkh-tuvshin Ulziisaikhan receives Colonel General Vladimir Zarudnitsky, Chief of the Military Academy of the General Staff of the Armed Forces of Russia. Mr. Zarudnitsky is visiting Mongolia at the invitation of the Director of Mongolian National Defense University.

ECONOMY

Stock price of Bayangol Hotel JSC rises 6.25 percent.

MTS Index of tourism increases 2.94 percent.

The Asian Development Bank (ADB) and Japan Fund for Poverty Reduction sign an MoU on granting MNT 2.5 billion soft loan to Mongolia for the improvement of water management and public utilities.

Top 20 Index falls 0.18 percent, to 19984.21 points. MSE A Index rises 0.23 percent, to 9655.38 points. MSE B Index falls 0.15 percent, to 9886.55 points. Market cap stands at MNT 2.46 trillion.

SOCIETY

Intellectual Property and Innovation: Backbone of Development forum takes place.



Justice Minister embroiled in a scandal of spying on 9 journalists

Batsaikhan.S / ZGM

Prosecutor's office confirms there is an ongoing investigation

Tugsbilig.B
@tugsbiligZGM

General Prosecutor's Office of Mongolia (GPO) held a press conference on a recent illegal surveillance case yesterday. Prosecutor in charge of public relations and monitoring of GPO Byasman Ganburged informed "The Police Authority reported to the General Intelligence Agency (GIA) of privacy breach case on certain journalists by a cer-

tain official. After an investigation, the GIA opened a criminal case on the officials and submitted to the GPO. The case is currently under investigation of the prosecutor's authority." However, the GPO refused to give further details on the names of victims or suspects.

Domestic media outlets have reported that the Minister of Justice and Home Affairs Nyamdorj Tsend presumably ordered to spy on certain journalists according to an anonymous post on social media. Mr. Nyamdorj has denied the allegations and told the media that the claims of threatening and wiretapping a journalist along with his/her family members, and shooting the media representative's car tire are an organized political scandal.

His answers peaked some attention because the information that went viral on social media never mentioned a tire but a vehicle. He disclosed a number of information regarding the surveillance scandal that was not public ahead of his statement. Also, the GPO spokeswoman did not deny when asked if the suspect was Nyamdorj.

The fact that Mr. Nyamdorj has been strongly criticizing matters of surveillance and wiretapping makes the matter of more importance if he is proven guilty. In the past, he was involved in several wiretapping and surveillance cases, all of which were settled without proper investigation in the past; for instance, surveillance on teachers in 1992-1996 when he was a member

of parliament and surveillance on MPRP head Enkhbayar Nambar and former PM Jasrai Puntsag in 1997. Also back in 2003, former MP Gundalai Lamjav claimed Nyamdorj as Chinese spy. Former General Baatar Jaalkhuu, who was investigating him, once said "There are witnesses who saw Nyamdorj with a Chinese officials. Even a photograph exists to prove it. However, the court ignored these evidence." Mr. Baatar was later imprisoned over a disclosure of state secret.

In addition, the Parliamentary Democratic Party's group demanded the Prime Minister to dismiss Mr. Nyamdorj over certain violation of budget law and other issues earlier this week. [ZGM]

FOREIGN RELATIONS

Indian FM Sushma Swaraj pays courtesy call on President of Mongolia

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Yesterday, the President of Mongolia Battulga Khaltmaa received Minister of External Affairs of India Sushma Swaraj on the sidelines of her official visit to Mongolia at the invitation of her Mongolian counterpart Tsogtbaatar Damin.

Beginning the meeting, President Battulga congratulated on Ms. Swaraj's official visit to Mongolia which is expected and trusted to be highly constructive in a way that it deepens cooperation between the two countries.

Expressing her satisfaction with the arrival in Mongolia, Ms. Sushma Swaraj shared that her meetings with the Mongolian head of state, government and parliament were constructive and that they are expected to expand the bilateral ties by major volume. The Indian FM also underlined that the Indian side has been attaching a major importance to the Joint Project on Oil Refinery in terms of its significance in helping Mongolia to achieve independence of fuel and petroleum supply.

While highlighting that historic, cultural and religious relations with India have been prospering, The President expressed interest in intensifying economic ties. The head of state also asked Ms. Swaraj to convey his greetings to the President and Prime Minister of the Republic of India.

The dignitaries exchanged views, with a focus on the future development of bilateral ties, on ways to promote cooperation in all sectors. [ZGM]

SOCIETY

Khushig Valley Airport conducts its first test-flight

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Khushig Valley New International Airport conducted its first test-flight on April 25. The flight testing was successfully performed by MIAT Airlines SOE's B737-800 aircraft. During the test-flight, precise and non-precise instrument approach procedure based on tradition navigation. MIAT Airlines SOE will check and approve the flight procedures and submit them to Civil Aviation Authority of Mongolia. The airport is scheduled to start operation in October 2018. "We have finished the constructions of initial blueprint in January 2017. Since then, an additional contract was signed. We were able to save around USD 40 million from the initial budget. Therefore, we agreed on building a maintenance hangar and parking garage," informed Enkhbat Navaantseden, Head of New Ulaanbaatar International Airport construction project. The joint management team between Mongolia and Japan will be responsible for the airport's profitability and loan repayments. "Japanese side will form 51 percent of the management team and the remaining 49 percent will consist of Mongolian workforce," previously said Bat-Erdene Jadamba, Minister of Road and Transport Development during his visit to the airport in January. [ZGM]

STOCK MARKET

BDSec's profit reaches MNT 1.1 billion

Oyunbayar.N
ZGM

MSE-listed BDSec JSC, which operates as an intermediary in the stock market, held its shareholders' regular meeting on April 23. During the meeting, several issues, such as board selection and approval of 2018 budget were discussed.

Last year, the company conducted 16.6 percent of stock trades and 29 percent of bond trades that took place at the MSE, the company's management reported. In addition, the management team highlighted that the company served as the underwriter for APU JSC's M&A with Heineken, which was a significant task for the company.

From its financial outcomes, it is seen that the company earned

MNT 2.24 billion revenue and net profit of MNT 1.1 billion or MNT 80.2 per share.

Although the profit indicators are positive, the Board of Directors decided not to distribute dividend to its shareholders as the company is requiring more investment. Currently, BDSec is working on a dual registration of TSX-listed Erdene Resources Development Corp and IPO of Ard Daatgal LLC. [ZGM]

And Energy increases dividends

MSE-listed And Energy JSC held its shareholders' regular meeting on April 25 and approved the Board of Directors' review to the 2017 operational and financial statements of the company. Last year, the sales revenue of And Energy totalled MNT 944.12 million and net profit - MNT 133.75 million. The profit saw MNT 261.7 million increase, which is 38 percent higher compared to the previous year and its profitability tripled year-over-year. Thus, the company

has decided to distribute dividend of 29 percent of its net profit or MNT 50 per share. However, the founders of the company, four major shareholders, announced that they have decided to distribute 80 percent of their dividend to other shareholders during the meeting, the Market info highlighted. According to the decision, MNT 33.88 million or MNT 127 per share will be distributed to other shareholders who hold a total of 26,544,058 shares. [ZGM]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2018.04.27

Тендер шалгаруулалтын нэр: Ус сувгийн удирдах газарт суудлын автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

Тендер шалгаруулалтын дугаар: УСУГ-ХА-2018-123

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендер оролцогчдоос суудлын автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 (тавин мянган) төгрөгний цахим тендерийн хураамж төлж орлоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Сүүлийн 2 жил 2016, 2017 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 жилд 2016, 2017 онд ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил тус бүр төсөвт өртөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 1,100,000 (нэг сая нэг зуун мянган) төгрөгний баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг дуустал.

Тендерийг 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 11 цаг 00-аас өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 11 цаг 30 минут-аас нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токнигийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар Утас: 70157019-223

INFRASTRUCTURE

Heavy-duty road to establish in Tavantolgoi-Gashuunsukhait route



Batsaikhan.S / ZGM

According to Bold Tsegmed, CEO of Gashuunsukhait Avto Road LLC, the establishment of a road parallel to the Tavantolgoi-Gashuunsukhait road that runs 247 kilometer is currently in discussion.

"Tender bid for the heavy-duty highway under a concession agreement has been announced recently," informed Mr. Bold. In addition, it was reported that Erdenes Mongol JSC and Erdenes Tavan Tolgoi JSC are studying the feasibility study of

the road to Khangi-Mandal border checkpoints. The annual capacity of coal transport in the Gashuunsukhait route is 21-22 million tons and a total of 17.1 million tons of coal was transported in this route as of the end of 2017. "In the future, there is a possibility to transport 30 million tons of coal a year through Gashuunsukhait checkpoint and thus, the establishment of twin roads is necessary," Mr. Bold highlighted. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 07.00** "Өглөө" хөтөлбөр
- 11.00** "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр /шууд/
- 14.00** "Зурхайч" Оросын уран сайхны кино 7, 8-р анги
- 16.40** Нийслэлийн ЗДТГ үзүүлж байна
- 18.55** Эрүүл мэнд эрхэм баян
- 22.15** "Хулгайлагдсан хүү" Туркийн олон ангит уран сайхны кино 15-р анги

Bloomberg TV Mongolia

- 07.00** Суутнуудын намтар нэвтрүүлэг
- 11.00** #Made in Mongolia Баримтат цуврал нэвтрүүлэг
- 14.00** Дэвид Рубенштейний шоу нэвтрүүлэг
- 18.00** Бизнесийн төв цэг Мэдээний хөтөлбөр - давталт
- 20.00** Блумбергийн ярилцах цаг нэвтрүүлэг
- 23.00** Мөнгөний урсгал Мэдээний хөтөлбөр давталт

БОЛОВСРОЛ HD

- 08.00** "4 өнгө" цаг агаарын хөтөлбөр
- 13.05** "Кино миний амьдрал" нэвтрүүлэг
- 14.05** "Аяг таа" шоу нэвтрүүлэг
- 15.45** "Аугаа уран зургууд" нэвтрүүлэг
- 19.00** "Төгс бэр" ОАК 31-р анги
- 22.10** "Көсөм" ОАК 2.83-р анги



- 06.30** Өнөө өглөө
- 10.30** "Хуурамч хэрэг" COAK 5 дугаар анги
- 14.00** "Хүрээлэн амьд ертөнц" 3 дугаар хэсэг
- 19.00** "Мөрдөгч хүүхдүүд" ОАК /season-2/ 41, 42-р анги
- 20.00** Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
- 22.30** "Empire" ОАК /season-3/ 6-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 12
Хаврын адаг улаан луу сарын зургаан цагаан мэнгэтэй, шарагчин үхэр өдөр
Үс засуулбал: Өвчин эмгэг ирнэ
Наран ургах, шингэх: 05.43-19.58
Барилдлага: Үл тохирох
Шүтэн барилдлага: Хуран үйлдэхүй
Суудал: Уул

Аргын тооллын 4 сарын 27. Сугар гараг. Билгийн тооллын 12, Тугчин одтой, шарагчин үхэр өдөр.
Өдрийн наран 05.43 цагт мандан, 19.58 цагт жаргана. Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал агдуус номхруулах, угаал үйлдэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Улааны үйлд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ОНЦЛОХ ҮЗВЭР

"Сэтгэлийн анир" юуг өгүүлэв



"The Voice of Mongolia" шигшээ тоглолт
Хаана: Монголын үндэсний АСА цирк
Хэзээ: 2018.04.28-29-ний 15.30 цагт
Тасалбарын үнэ: ₮ 20-30 мянга



"Night of Ballet" гала тоглолт
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2018.04.29-ний 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга



"Миний сонсож өссөн дуунууд" концерт
Хаана: Ulaanbaatar Palace
Хэзээ: 2018.04.28-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 20 мянга




Найруулагч Э.Чинзоригийн бүтээл
"Сэтгэлийн анир" уран сайхны кино
"Өргөө" кино театрын дэлгэцнээ

гарч байна. Хүний амьдралын, гэр бүлийн үнэ цэнийг харуулсан уг бүтээлийн гол дүрд жүжигчин О.Долгор, Э.Мөнхтөр, А.Баттүшиг нар тогложээ. Төгс хэмээх залуу эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар эхнэр Анираа дагуулан нэгэн буйдхан тосгонд ирснээр үйл явдал эхэлнэ. Буйдхан газар хосууд улам бүр ойртож, бие биедээ гаргах цаг бүр ч их олдоно гэж бодсон ч тэд

шинэ орчинд олон жил амьдрахдаа бие биенээсээ олж хараагүй зан чанаруудыг таньж мэднэ. Ийнхүү хосуудын харилцаанд үл ойлголцол үүсч, эцэст нь амьдралаа авч үлдэх үү гэх асуулттай тулгардаг. [ЗГМ]



"Өргөө" кино театрт цацагдаж байгаа бусад киноны трейлерийг энэхүү QR кодыг уншуулж үзнэ үү.



"Яллагч" УСК-ны нээлт
Хаана: The Corporate Hotel & Convention Centre
Хэзээ: 2018.05.03-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 15 мянга




"Кихот ноён" жүжиг
Хаана: УДЭТ
Хэзээ: 2018.04.28-29-ний 18.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-30 мянга



"Faust" пост драм
Хаана: СТӨ
Хэзээ: 2018.05.02-03-ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 20-80 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



- БОСООГООР:**
2. Даах хэмжээ
 3. "Ягаан ноён" гэж алдаршсан Алтан ургийн хан
 5. Монголчуудын уламжлалт хатааж бэлтгэсэн мах
 8. Мал амьтны өвчин
 9. Төлгө
 11. Уурганы үзүүр дэх оосор
 12. Дундад Азийн улс

- ХӨНДЛӨНГӨӨР:**
1. Төрийн шагнал
 4. Бодончарын хүү
 6. Харгуй
 7. Нэрт шог зураач,

- зохиолч, СГЗ
10. Эвлүүлж залгах үйл
11. Энэрэнгүй, хүнлэг утга
13. Нэгэн зүйл тогоруу
14. Ааш зан
15. Японы домогт уул

Өмнөх дугаарын хариу / 04.26

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| С | У | Л | И | Н | Х | Э | Э | Р |
| Я | | А | | | | | Л | |
| Х | А | Р | А | Й | Г | Ч | | |
| А | | | Д | | | И | | |
| Н | А | Р | Г | И | А | Н | | |
| | | | | | А | | | |
| | | | Х | А | Й | Р | С | |
| Ш | И | И | | | | У | Р | Д |
| И | | | А | А | Д | А | Р | А |
| Н | | | | | | | | Н |
| Э | Н | Х | М | А | Н | Л | А | И |


ЗГМ: СҮДОКУ

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 5 | | | | | |
| | | | 5 | 9 | | | | | 4 |
| | | 3 | 2 | 4 | | 6 | 9 | 5 | |
| 1 | | | | | | 9 | 8 | 3 | |
| 7 | | | | | | | 6 | | |
| 4 | 9 | | | | 8 | | | | |
| | 1 | | 8 | | 6 | | | 4 | 3 |
| | 8 | | 4 | 3 | 9 | 1 | | | |
| | | | | 2 | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|--|
| 4 | 7 | 9 | 6 | 1 | 8 | 2 | 3 | 5 | |
| 8 | 2 | 3 | 9 | 7 | 5 | 4 | 1 | 6 | |
| 5 | 1 | 6 | 4 | 3 | 2 | 9 | 8 | 7 | |
| 7 | 4 | 5 | 2 | 9 | 1 | 3 | 6 | 8 | |
| 2 | 6 | 1 | 5 | 8 | 3 | 7 | 9 | 4 | |
| 3 | 9 | 8 | 7 | 4 | 6 | 5 | 2 | 1 | |
| 1 | 3 | 4 | 8 | 2 | 7 | 6 | 5 | 9 | |
| 6 | 8 | 7 | 3 | 5 | 9 | 1 | 4 | 2 | |
| 9 | 5 | 2 | 1 | 6 | 4 | 8 | 7 | 3 | |

ЦАГ АГААР

| УЛААНБААТАР | IV.27 | IV.28 | IV.29 | IV.30 | V.01 |
|-------------|----------------|----------------|---------------|---------------|-----------------|
| | 25° / 9° | 8° / 5° | 11° / -2° | 11° / -1° | 14° / 0° |
| | 12 м/с / 8 м/с | 10 м/с / 8 м/с | 7 м/с / 6 м/с | 6 м/с / 6 м/с | 8 м/с / 6 м/с |
| | Үүлшинэ | Бороотой | Үүлшинэ | Үүлшинэ | Багавтар үүлтэй |



ЗГМ: КОМИКС

[ЗГМ СӨНИН]

Mr. Баагийгийн ПАЯН....

...зөөгч хийгээд л...
ай ахын лүү олигойхон ажил олж хий л дээ... амьтан хүнтэй танилцаад ахих дэвшихээр ажил хий..

...зөөгч хийгээд л...
дээ сургууль төгссөн гээ биз дээ... хүн шиг ажил олдохгүй байна уу?

...зөөгч хийгээд л...
хэдэн төгрөг олдог ажил хийгээч ээ? зөөгчийн мөнгөөр яаж амьдрал байна аа?

сүрхий ажил хийхгүй юм бол хүн биш юм уу?

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

| | | |
|--------------|-------|-------|
| УБ-МОСКВА | 13.50 | 14.28 |
| ЭРЭЭН-УБ | 18.00 | 11.15 |
| УБ-БЭЭЖИН | 07.15 | 14.04 |
| ХӨХ ХОТ-УБ | 22.50 | 11.15 |
| УБ-ХӨХ ХОТ | 20.00 | 20.49 |
| УБ-ЭРХҮҮ | 21.10 | 02.40 |
| ЭРХҮҮ-УБ | 15.35 | 06.20 |
| УБ-СҮХБААТАР | 21.15 | 05.12 |
| СҮХБААТАР-УБ | 20.55 | 05.03 |
| УБ-ЭРДЭНЭТ | 20.30 | 07.45 |
| ЭРДЭНЭТ-УБ | 19.10 | 05.48 |
| УБ-САЙНШАНД | 09.15 | 19.15 |
| САЙНШАНД-УБ | 20.25 | 07.01 |

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

| | | |
|------------|-------|-------|
| УБ-МОСКВА | 09.15 | 10.55 |
| УБ-БЭЭЖИН | 17.55 | 20.10 |
| БЭЭЖИН-УБ | 21.10 | 23.40 |
| УБ-ХОНКОНГ | 06.25 | 10.55 |
| ХОНКОНГ-УБ | 12.05 | 16.45 |
| УБ-СӨҮЛ | 08.40 | 12.50 |
| СӨҮЛ-УБ | 14.20 | 17.00 |
| УБ-ТОКИО | 07.45 | 13.40 |
| ТОКИО-УБ | 14.40 | 19.15 |
| УБ-ЭРХҮҮ | 07.50 | 09.15 |
| ЭРХҮҮ-УБ | 10.15 | 11.45 |

Facebook-ийн орлого Уолл Стритийг доргиов

Facebook-ийн орлого оны эхний улиралд бараг таван тэрбум ам.долларт хүрч жилийн өмнөх үеэс 63 хувиар өсөв. > 10


Брюссель Apple-ын наймааг шалгаж эхэллээ

Shazam-ыг худалдан авах наймаа Apple-ийг хэт хүчирхэгжүүлэх аюултай хэмээн Брюссель болгоомжилж байна. > 10

Хятадын авлигын эсрэг бодлого Хонконг руу чиглэж байна

Ажилтнуудын паспортыг хураах нь Хонконгийн хуулийг зөрчсөн хэрэг гэдгийг арлын Хөдөлмөрийн албанаас мэдэгдэв. > 10

Кофены үнэ ойрын ирээдүйд үргэлжлүүлэн унана



BMMO

Эмиго Терасоно

Хедж сангууд кофены зах зээлийг унагасан тул ойрын ирээдүй нь түгшүүртэй харагдаж байна. Дэлхийн кофены үйлдвэрлэлд тэргүүлэгч Бразил улс энэ жил дээд хэмжээний ургац авах төлөвтэй байгаагийн дээр импортлогч орнууд сайн чанарын арабака кофе илүүд үзэх болжээ. Өнгөрсөн долоо хоногт Нью Йоркийн бирж дээр нэг фунт кофены үнэ хоёр жилийн доод түвшин рүү унаж, 115.30 цент болсон. Гэхдээ буцаад жаахан сэргэсэн ч олонх фермерийн хувьд өөрийн өртгөөсөө доогуур арилжигдаж байна.

Хедж сангууд болон бусад дамлагчид өнгөрсөн оны дундаас арабака сортоос татгалзаж эхэлсэн нь зах зээлд гайхал төрүүлжээ. Mages Spectron брокерийн фирмийн хөдөө аж ахуйн таваарын хэлтсийн



ахлагч Жэймс Хирн үнийн уналт гайхалтай байсныг онцлоод “Хэдий хүртэл хангалттай унах вэ?” гэж асуужээ. Зах зээл гэнэт өсөж, тогтворгүй байдал үүсгэнэ гэсэн мэдээг үл харгалзан хедж сангууд уналт дээр тоглосор байв. Одоо хуримтлагдаад буй 60 кг-аар савласан 20 сая шуудай кофе 2018-2019 оны дэлхийн нийлүүлэлтийн таамгаас 4-6

дахин илүү гарчээ.

Энэ байдлыг ойлгох түлхүүр нь кофены үнийн бүтцийг ажиглахад кофены илүүдэл ирэх онд ч үргэлжлэх төлөвтэй байна. Өнгөрсөн оны дундаас эхлэн нэн даруй нийлүүлэх кофены үнэ форвард гэрээнийхээс доогуур байгаа нь хедж сангууд үнийг унагаж, урт хугацааны фьючерсээс ашиг олж байна гэсэн



үг юм. Тогтвортой зах зээлд бол одоогийн үнийн бүтэц жилийн дүнгээр 11 хувь сэргэх ёстой гэж Rabobank-ны шинжээч Карлос Мера тооцож байна.

Бразилын ургацын таамаг болон (албан таамаг 58.5 сая шуудай буюу өмнөх оноос гуравны нэгийг өснө гэж буй боловч зарим шинжээч 65 сая шуудайд хүрнэ гэжээ) хэлбэлз-

лийн түвшин доогуур байгаа. Үүнээс хамааран үнийн бүтэц өөрчлөгдөх шинжгүй байгаа тул ойрын үед үнэ дээшлэх төлөв харагдахгүй байна. Таваарын нөөц илүүдсэн нь мөн хэлбэлзэл бага байх нөхцөлийг бүрдүүлж буй. Кофены үнэ доогуур байгаа үед олон фермер ургааа худалдахаас түдгэлзэж байгаа юм. Ноён Мера хэлэхдээ

“Сангууд одоо үнэ дээшилбэл зарагдаагүй кофе зах зээлд гарна гэдгийг мэдэж байгаа” гэжээ.

Япон, Европ, АНУ-ын импортлогчдын нөөц харьцангуй арвин байгаа нь Бразилын мөнгөн тэмдэгт реал сул байгаа үед үнэ нэмэгдэхээс хамгаалах зөөлөвч болж байна. Тус улсын фермерүүд ургацаа ам.доллараар худалдаж орлогоо нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь дэлхийн зах зээлийн үнэ унах бас нэг шалтгаан болжээ. Гол асуудал арабака сортын үнээс хамаарч байгаа гэнэт үнэ өсөх мэдээ нөхцөл байдлыг эргүүлж магадгүй. Бразилд гэнэт хүйтрэх буюу Төв Америк, Колумб зэрэг улсад хямд үнийн улмаас ургац буурвал зах зээлийн өнөөгийн үнэ дээшлэх боломжтой. Ноён Хирн “Байдал болгох зорилгоор үнэ дээшлэх хэт өөрчлөгдөвөл үнэд хэт нөлөөлөх эрсдэлтэй” гэж анхааруулжээ.



АНУ-ын банкууд баталгаагүй зээл олгох эрсдэл нэмэгдэв

Бен МкЛаннахан

Трампын засаг захиргаа богино хугацааны, жижиг зээл олгох журмыг зөвлөрүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь АНУ-ын банкууд хэдэн арван сая бага орлоготой өрхүүдэд зээлээ хүргэх боломж нээнэ. Банкууд бэлэн мөнгө муутай хүмүүст баталгаагүй зээл олгохоос болгоомжилдог уламжлалтай ч ийм зээлийн журам маш хатуу хэмээн гомдоллосор ирсэн. Нөгөө талаас жилийн бодит хүү нь нэлээд өндөр зээл олгох нь нэр хүндэд муугаар нөлөөлөхийн зэрэгцээ ийм бизнес ашгаас илүүтэй асуудал авчирна гэсэн бодол эдийн засагч ч, тэдэнд ч сайн зүйл” гэжээ. 2013 онд өмнөх засаг захиргаа аваад нэг дор буцаан төлдөг зээлийг хязгаарлахыг банкуудад сануулж байсан юм. US Bancorp, Regions



BMMO

Financial, Fifth Third зэрэг орон нутгийн томоохон банкууд энэ сегментэд харьцангуй идэвхтэй ажиллаж байжээ.

Ноён Оттинг Well Fargo, BoA, JPMorgan зэрэг үндэсний хэмжээний банкуудыг зохицуулах ажлыг хариуцдаг. Тэрбээр Холбооны хадгаламжийн даатгалын корпорац, Санхүүгийн тогтвортой байдлыг хянах зөвлөл хэмээх хоёр байгууллагын удирдлагад ордог аж. Ноён Оттинг уулзалт дээр төлөвлөгөөний талаар нарийн зүйлийг тодруулаагүй боловч нэг дор төлдөг гэхээс илүүтэй хэсэгчлэн буцаан төлдөг зээлийг дэмжиж буйгаа илэрхийлэв.

Цалин тогтмол атал эмчилгээний төлбөр гэх мэт нэг удаад төлөх шаардлагатай үйлчилгээний үнэ өссөөр байгаа учир баталгаатай зээл сүүлийн жилүүдэд түргэн тэлжээ. Өнгөрсөн онд Холбооны нөөцөөс явуулсан судалгаанд Америкийн өрхүүдийн бараг хагас нь 400 ам.доллараас дээш гэнэтийн зардлыг зээлэх буюу ямар нэг зүйл заралгүйгээр төлөх чадваргүй байгааг илрүүлжээ. Үүнийг дагаад онлайн зээлдэгчид

орж ирсэн зээлийн кредит багатай буюу огт байхгүй хэрэглэгчдийг онилж байна.

Түүнчлэн зарим томоохон ажил олгогчид уг асуудлыг шийдэхийн тулд орлого, зарлагыг зөв зохицуулах арга зам санал болгодог. Жишээ нь, Walmart өөрийн 1.4 сая ажиллагсадд үйлчлэхийн тулд Procter & Gamble фирмтэй хамтран бодогдсон боловч төлөгдөж амжаагүй цалингаа ашиглах боломж олгосон байна. Банкинд ажиллаж байгаад одоо Wboardmoog зөвлөх фирмийг толгойлж буй Тодд Бейкер хэлэхдээ банкуудаас олгох цөөн долларын зээл доогуур болон цагтаа олгогддоггүй цалингийн үндсэн асуудлыг шийдэхгүй хэмээн сануулав. Гэхдээ хэрэглэгчид дэлгүүрээс юм авахын тулд хаана ч хамаагүй өр тавихаас чөлөөлөгдөвөл хүчирхийлэл, дээрэмд өртөх магадлал багасна гэжээ. Тэрбээр “Бага орлоготой хүмүүст зардлаа төлөх мөнгө хэрэгтэй байна. Түүнийгээ зохицуулалттай банкнаас авдаг бол хамаагүй дээр байхсан” хэмээв.



Санаатай дефолт - зах зээлийн манипуляц

Кадим Шуббер, Жо Реннисон

CDS (Credit Default Swap) буюу зээлийн дефолтын своп хэлцлийн төлбөр авахын тулд санаатай дефолт үүсгэдэг явдлыг АНУ-ын дериватив буюу үүсмэл үнэт цаасны тэргүүлэх зохицуулах байгууллага шүүмжилж байна. Санаатай дефолт нь “зах зээлд манипуляц үүсгэх” аюултайг тус байгууллага анхааруулав.

Blackstone групп эзэмшдэг GSO хедж сан болоод үл хөдлөх хөрөнгийн Novnapan компанийн хоорондох маргаантай наймаа дуулиан дэгдээсний дараахан АНУ-ын таваарын фьючерсийн арилжааны комисс (US Commodity Futures Trading Commission) уг анхааруулгыг гаргажээ. Үл хөдлөх хөрөнгийн дизайн, барилга угсралт, борлуулалт хамарсан өргөн цар хүрээтэй үйлчилгээ үзүүлдэг Novnapan компани зарим бонддоо дефолт зарлах гэж байгаа нь шуугиан дэгдээсэн юм.

GSO хедж сан Novnapan-д таатай нөхцөл бүхий хүүтэйгээр 320 сая ам.долларын дахин санхүүжүүлэлт хийх хэлэлцээрийг энэ онд байгуулсан. Гэхдээ Novnapan компани “үүс-юм авахын тулд хаана ч хамаагүй өр тавихаас чөлөөлөгдөвөл хүчирхийлэл, дээрэмд өртөх магадлал багасна гэжээ. Тэрбээр “Бага орлоготой хүмүүст зардлаа төлөх мөнгө хэрэгтэй байна. Түүнийгээ зохицуулалттай банкнаас авдаг бол хамаагүй дээр байхсан” хэмээв.

CDS буюу зээлийн дефолтын своп хэлцэл нь компаниуд зээлээ төлж чадахгүй нөхцөлд хөрөнгө оруулагчдыг хамгаалах хэрэгжүүр болдог. Novnapan-ы CDS-ийг худалдаж авсан GSO

сан дефолтоос орлого олох тооцоотой.

Харин үл хөдлөх хөрөнгийн компани дефолт зарлал түүний CDS-ыг зарсан Solus Asset Management шиг арилжаач нар үлэмж алдагдал хүлээж таарна. GSO сан, Novnapan хоёрыг Solus компани шүүхэд өгөөд байна. АНУ-ын манипуляц үүсгэх” аюултайг тус байгууллага анхааруулав.

“Санаатай дефолт нь зах зээлд манипуляц үүсгэж, CDS зах зээлийн ажиллагааг ноцтой бусниулна” хэмээн Таваарын фьючерсийн арилжааны комисс үзэв. “CDS зах зээл нь тухайн CDS гэрээнд заагдсан компани дефолтоос зайлсхийх нөхцөлд тулгуурлаж ажилладаг. Энэхүү хэрэглүүрийн үнийг тодорхойлогч нь гэрээнд заагдсан компанийн санхүүгийн нөхцөл. Гэтэл зориудын санаатай дефолт үүсгэх зорилго бүхий сүүлд болж өнгөрсөн хэрэг энэхүү нөхцөлийг эргэлзээтэй болгов”.

GSO-гийн шаардлага “CDS индекстэй бүтээгдэхүүний зах зээлийн бүрэн бүтэн байдалд хохирол учруулж, эрсдэлээс өөрсдийгөө хамгаалахын тулд

CDS ашигладаг дилер, арилжаач, худалдааны платформ, клирингийн танхим, зах зээлд оролцогчдод сөрөг нөлөөлөх” аюултайг Таваарын фьючерсийн арилжааны комисс анхааруулав.

Дефолт зарлах нөхцөл бүхий дахин санхүүжүүлэх гэрээ хэлцэл CDS зах зээлд анх удаа тохиолдож байгаа хэрэг бус. GSO сан дээрхтэй төстэй тохиролцоог санхүүгийн хүндрэлтэй тулгарсан Испанийн компьютер тоглоомын компанитай 2013 онд байгуулахаар оролдож байжээ.

Энэ сард Олон улсын своп, деривативын холбоо (International Swaps and Derivatives Association) мөн санаатай дефолт үүсгэх оролдлыг шүүмжилсэн. Цаашид зээлийн үүсмэл үнэт цаасны гэрээний үндсэн нөхцөлд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаагаа тус холбоо дурдсан юм.

“Зохицуулах бусад байгууллагын хамтаар зах зээлийн бүрэн байдлыг хамгаалж, CDS-тэй холбоотой луйвар, манипуляцтай тэмцэхэд бүх хүчээ дайчлах”-аа Таваарын фьючерсийн арилжааны комисс мягмар гаргт мэдэгдлээ.

Комиссын мэдэгдэлтэй холбогдуулан Novnapan “манай сүүлийн транзакцууд компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцэж буйд итгэл төгс байгаа”-гаа тайлбарлав.

Solus болон Blackstone компаниуд уг үйл явдалтай холбогдуулан тайлбар өгсөнгүй.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



Брюссель Apple-ын наймааг шалгаж эхэллээ

Ровелл Топленски, Тим Брэдшоу

Apple компани Shazam-ыг 400 сая ам.доллараар худалдан авах наймааг Брюссель саатуулан шалгаж эхэллээ. Европын холбоо уг наймаа нь iPhone үйлдвэрлэгчийг хэт хүчирхэгжүүлэх аюултай хэмээн үзэж байна. Асар их өгөгдөл хуримтлуулсан Shazam нь дэлхийд хамгийн түгээмэл хэрэглээтэй программын нэг. Энэхүү программ нь хэрэглэгчдэд сонсож буй хөгжмөө таних, танысан хөгжмөө Spotify, Apple Music, Deezer, Google Play Music зэрэг стриминг үйлчилгээгээр дамжуулан дахин дахин сонсох боломж олгодог юм. Нэг тэрбум гаруй удаа татагдсан энэхүү программыг хүмүүс өдөрт 20 сая гаруй удаа нээж ашигладаг.

Shazam нь мөн хөгжмийн үйлдвэрлэлийн салбарыг өгөгдлөөр хангаж, дуу бичлэгийн компаниуд хэрэглэгчдийн таашаал, сонирхлыг ойлгоход тус болдог. Apple уг компанийг өөртөө

үйлчилгээний бизнесийг 240 гаруй сая хэрэглэгч төлбөртэй ашиглаж байжээ. Shazam-ын өгөгдөл нь Spotify-гийн хамгийн хэрэглээ сайтай үйлчилгээний нэг Discover Weekly-тэй ижил үйлчилгээ нэвтрүүлэх боломжийг Apple Music-т олгоно. Discover Weekly нь хэрэглэгчдээ орж ирдэг өгөгдөл үндэслэн нийтлэг дууны жагсаалтыг автоматаар гаргадаг. Spotify компани худалдаж авсан The Echo Nest хэмээн хөгжмийн дүн шинжилгээний стартап компани анх уг үйлчилгээг санаачилжээ.

Spotify онлайн видео контентын Hulu компанитай хамтран ажиллахаар болсноо саяхан мэдэгдсэн. Hulu нь Spotify-гийн хөгжмийн товёгийг телевизийн сайн киногоор баяжуулан, Apple, өрсөлдөгч Amazon-ы шахалтад хариу болж өгнө. “Нэгтгэх ажиллагаанаас болж хөгжмийн хорхойтнуудын сонголт цөөрч,



нэгтгэх тохиолдолд өгөгдлийг нь ашиглан өрсөлдөгчдийнхөө үйлчлүүлэгчдийг булааж, “Apple Music үйлчилгээнд шилжүүлэх эрсдэлтэй” хэмээн Европын комисс болгоомжилж байна. Shazam программын өгөгдлийг бусад компаниудад ашигладаг явдлыг Apple компани зогсоовол өрсөлдөгчид нь хохирох эсэхийг тус комисс судалж эхлэв.

Apple Music нь 40 сая гаруй идэвхтэй хэрэглэгчтэй. Энэхүү 40 саяын бараг тал нь өрсөлдөгч Spotify компанийн үйлчилгээг давхар ашигладаг. Харин Spotify-гийн нийт үйлчлүүлэгч 2017 оны эцсээр 71 саяаг давжээ. Shazam-ыг нэгтгэх наймаа болон сэтгүүл захиалгын Texture аппликэйшныг өнгөрсөн сард худалдан авсан нь үйлчилгээний судалгаанд өргөжин тэлэх Apple-ын стратегийн чухал бүрдэл. Apple компанийн үйлчилгээний салбарын борлуулалт 2020 он гэхэд 50 тэрбум ам.долларт хүрнэ хэмээн найдаж байна.

Өнгөрсөн оны 12 дугаар сарын эцсийн байдлаар Apple Music, iCloud, App Store зэрэг Apple-ын

хумигдах аюулгүйг баталгаажуулах нь бидний шалгалтын зорилго” хэмээн Европын холбооны өрсөлдөөний хэрэг эрхэлсэн комиссар Маргрет Вестагер тайлбарлав. Apple-ын наймаа хил дамнан шинжтэйг долоон улс Европын өрсөлдөөний хэрэг эрхэлсэн комисст анхааруулсны дараа хоёрдугаар сард Брюссель мөрдөн шалгаж эхэлсэн юм. Урт удаан үргэлжлэх шалгалтын дүгнэлт есдүгээр сард гарах ёстой.

Шалгалттай холбогдуулан тайлбар өгөхөөс Apple татгалзаж байна. Уг наймаа нь нийтэд алдаршсан дижитал компаниудыг цөөн хэдэн онлайн аваргууд залгиж буйн сүүлийн шинэ жишээ хэмээн Европын хэрэглэгчийн байгууллагын (The European Consumer Organisation) тэргүүн зөвлөх Агустин Рейна шүүмжилж байлаа. “Хэрэглэгчдийн өгөгдлийг цөөн хэдэн онлайн тоглогч шударга өрсөлдөөнд хохиrolтойгоор залгиад байж болохгүй” хэмээн тэрбээр дургүйцсэн юм.

Facebook-ийн орлого Уолл Стритийг доргиов

Ханна Кюклер

Сошиал сүлжээний контент, хувийн өгөгдлийн халдашгүй байдлын хамгаалалтын асуудлаар маргаантай байгаа Facebook-ийн ашиг орлого оны эхний улиралд эрс сайжирчээ.

Гуравдугаар сарын 17-нд Cambridge Analytica-тай холбоотой дуулиант хэрэг дэгдэхээс өмнөх үеийнхтэй нь харьцуулахад 14 хувиар уначихаад байсан Facebook-ийн хувьцааны ханш уг мэдээний дараа лхагва гарагийн арилжаагаар долоон хувь өсөв.

Тус компанийн орлого оны эхний улиралд бараг таван тэрбум ам.долларт хүрч, жилийн өмнөх үеэс 63 хувиар арвижлаа. Нэгж хувьцаанд ноогдох ашиг шинжээчдийн таамгаас 25 хувиар их буюу 1.69 ам.доллар болов. Уг нь шинжээчдийн дундаж таамаг 1.35 ам.доллар байсан юм.

Үндсэндээ зар сурталчилгаанаас ордог Facebook-ийн орлого оны эхний улиралд үсрэнгүй нэмэгджээ. Борлуулалт 49 хувиар өсөж бараг 12 тэрбум ам.доллар болсон нь 11.4 тэрбум хэмээн тооцоолж байснаас их байгаа юм. Сурталчилгааны нийт орлогоын 91 хувь нь мобайл салбараас оржээ.

Трампын сонгуулийн кампанид зүтгэсэн өгөгдлийн шинжилгээний Cambridge Analytica компани 87 сая хэрэглэгчийнх нь мэдээллийг задруулсан хэрэг илэрснээс



үүдэн энэ оны эхний улирал Facebook-ийн удирдлагад хүнд үе байв. Өгөгдөл алдагдсан анхны мэдээлэл нэгдүгээр улирлын сүүлийн 14 хоногт гарсан учраас дуулиант хэргийн нөлөө хараахан илэрч амжаагүй байж болзошгүй. Гэхдээ Facebook хуурамч мэдээллээс сэргийлэх, тус платформтой холбоотой улс төрийн маргааныг намжаахын тулд хэрэг дэгдэхээс өмнө хэвлэлийн компани, бизнесийнхээс хэрэглэгчийн ар гэр, анд нөхдөл илүү ашигтай чиглэлд мэдээллээ өөрчилж эхэлсэн юм.

Facebook-д “чухал сорилт” тулгарсан ч 2018 оны эхний улиралд бизнес “гараа сайтай” байгааг тус компанийг үндэслэгч, гүйцэтгэх захирал Марк Зукерберг лхагва гарагт дахин мэдэгдлээ. Хорвоо ертөнцийн

холбож өгөх Facebook-ийн үндсэн зорилгоос ухрахгүй гэдгээ тэрбээр хөрөнгө оруулагчдадаа мэдэгдлээ. “Бид үүрэг хариуцлагаа илүү ухамсарлаж, манай үйлчилгээ сайн сайхан зорилгод чиглэж буйг баталгаажуулахаар хөрөнгө оруулж байна. Үүний зэрэгцээ бид хүмүүсийг холбож, манай нийгмийг бэхжүүлэх, дэлхий ертөнцийг нэгтгэн нягтруулахад ашиглах шинэ хэрэглүүр бүтээх шаардлагатай боллоо” хэмээн тэр тайлбарлав.

Тус компани хөрөнгө оруулагчдадаа өгөх ногдол ашгаа ихэсгэж, хувьцаа худалдан авах мөнгөний хэмжээг анх зургаан тэрбум ам.доллараар төсөвлөснөөс эсвэл тэрбум болгож нэмэхээр шийдсэнээ мэдэгдэв. Хувьцаа эргүүлэн худалдаж авах уг хөтөлбөр үндсэндээ төгсгөлийн

шатандаа ороод байна.

Cambridge Analytica-гийн хэрэг илэрсний дараа #delete-Facebook кампани өрнөж, улс төрийн маргаан дэгдсэн ч хэрэглэгчид нь оны эхний улиралд олон нийтийн сүлжээг орхисонгүй. Тус компанийн мэдээллээр хангах алгоритм өөрчлөгдсөн нь хэрэглэгчдийн тоо, олон нийтийн сүлжээнд өнгөрөөх цагийг багасгах сөрөг нөлөөгүй өнгөрөв.

Энэ оны гуравдугаар сарын эцсийн статистикаас үзвэл Facebook-ийг 2.2 тэрбум хэрэглэгч идэвхтэй ашиглаж байгаа нь жилийн өмнөх мөн үеэс 13 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр хэрэглэгчийн 1.5 тэрбум нь тус сайтад өдөр бүр нэвтэрч байна.

Facebook-ийн нэг хэрэглэгчээс ордог орлогоор АНУ, Канад улс тэргүүлдэг. Тус хоёр зах зээлийн өдөр тутам идэвхтэй хэрэглэгчийн тоо анх удаа буурч, 2017 оны гуравдугаар улирлынхтай ижил буюу 185 сая болжээ.

Оны эхний улиралд Facebook-ийн үйл ажиллагааны орлого жилийн өмнөх үеэс таван хувиар сайжирч, 46 хувьд хүрлээ. Тус компани олон мянган модератор шинээр хөслөхөөр төлөвлөж байгаа нь цаашдын үйл ажиллагааны орлогод нь нөлөөлж болзошгүй. **FT**

Хятадын авлигын эсрэг бодлого Хонконг руу чиглэж байна

Дон Вейнланд

Хятадын төрийн өмчит хүчирхэг компани дахь авлигыг цэвэрлэх ажиллагаа Хонконгийг хамарч, албан тушаалтнуудын паспортыг хурааж авсан явдал Коммунист намын хяналтын хүрээ газар нутгаасаа хальж буйн илрэл болов. Huagong хөрөнгийн менежментийн компанийн Хонконг дахь салбарын ажилтнуудын аяллын баримт бичгийг хураан авч, шийтгэл хүлээлгэж болзошгүй байгааг Financial Times сонинд ирүүлсэн мэйлд бичсэн байна. Huagong-ын захирал Лай Сиоминыг сахилга батыг ноцтой зөрчсөн гэх үндэслэлээр мөрдөн байцааж байгаа талаар өнгөрсөн долоо хоногт мэдээлэгдсэний дараа ийм арга хэмжээ авчээ.

2012 оноос хойш муу зээл худалдан авах ажлыг хариуцаж байсан 55 настай ноён Лайд ямар хэрэг тулгасан нь тодорхойгүй байна. Huagong мөрдөн байцаалтын үеэр ажиллагсдын паспортын талаар асуултад хариулахаас татгалзав. Хонконгт эх газраас ирж ажилладаг боловч

байнгын оршин суугч биш хүмүүст паспорт маш хэрэгтэй баримт бичиг. Манай сонины олж авсан мэдээгээр зарим ажилтан паспортаа хүлээлгэн өгсөн аж. Ажилтнуудын паспортыг хураах нь Хонконгийн хуулийг зөрчсөн хэрэг гэдгийг арлын Хөдөлмөрийн албанаас мэдэгдэв. Тус байгууллагын төлөөлөгч хэлэхдээ “Ажил олгогчид ажиллагсдынхаа аяллын баримт бичгийг хураах ямар ч эрх мэдэл байхгүй” гэжээ.

Паспортаа хураалгах шаардлагыг Huagong-ын зохион байгуулалтын хэлтсээс ирүүлсэн бөгөөд энэ нь Коммунист нам дахь яамны түвшний эрх мэдэлтэй хороонд тайлагнадаг аж. Ийм хэлтэс улсын өмчлөлтэй бүх компанид ажиллаж, хүний нөөцийн асуудал эрхэлдэг ч Бээжинд шууд харьяалагддаг байна. Huagong-н Хонконг дахь салбарт хэдэн зуун хүн ажилладаг. Хятадад бол ийм арга хэмжээ явуулах нь улсын өмчтэй компаниудад ердийн зүйл. Ерөнхийлөгч Ши Жиньпийн таван жилийн өмнө эхлүүлсэн



авлигын эсрэг компанийн хүрээнд байгуулагдсан Сахилгын хяналтын комиссын шалгалтад хамрагдсан эх газар дахь компаниудын ажиллагсдын аялах эрхийг хаадаг.

Хонконгийн их сургуулийн профессор, Хятадын авлигын асуудлыг судалдаг Жу Жианнан “Дээд удирдлага нь байцагдаж буй үед байгууллагыг бүхэлд нь царцаах нь хэвийн зүйл.

Гол шалтгаан нь бусад хүмүүс зугтан гарах буюу хөрөнгө шилжүүлэхээс сэргийлэх явдал” гэв. Британийн колони байсан Хонконгт Хятадын хуулийг хэрэгжүүлдэггүй. Долоон сая хүн

амтай энэ газар нутаг гол хууль хэмээх өөрийн Үндсэн хуультай бөгөөд өөртөө засах эрхтэй юм. Гэвч сүүлийн жилүүдэд хоёр нэгжийн хуулийн ялгаа арилсаар байна. **FT**

Ажилтнуудын паспортыг хураах нь Хонконгийн хуулийг зөрчсөн хэрэг гэдгийг арлын Хөдөлмөрийн албанаас мэдэгдэв.

Эдийн засаг

Хөрөнгө оруулагчдын гэх тодотголтой арав гаруй чуулган болжээ

Г.Байгал
@baigalZGM

Дорнын сувд гэгддэг Хонконгод энэ сарын эхээр Монголд хөрөнгө оруулагчдын чуулган болж, өндөрлөлөө. Уг чуулганы цуваа үргэлжилсээр, ирэх зургадугаар сарын 8-нд Их Британийн Лондон хотод Монголд хөрөнгө оруулагчид дахин чуулах нь. Ийнхүү ар араасаа цуварсан хөрөнгө оруулагчдын чуулганыг сүүлийн 10 гаруй жил Улаанбаатараас гадна дэлхийн эдийн засгийн зангилаа төвүүдэд зохион



С.Батсайхан /ЗГМӨ

Үр дүнгүй чуулганууд хөрөнгө оруулагчдыг залхааж эхлэв үү

байгуулсаар ирлээ. Өнгөрсөн оноос энэ оны эхэн хүртэл зөвхөн хөрөнгө оруулагчдын гэх тодотголтой арав гаруй чуулган Улаанбаатар болон Хонконг, Лондон, Токио зэрэг хотуудад болсон байна.

Гэвч чуулган, уулзалтын тоо олширч, давтамж нь нэмэгдэхийн хэрээр ач холбогдол, үнэ цэн нь буурч буй урвуу хамаарал ажиглагдах болов. Сүүлийн үеийн хөрөнгө оруулагчдын чуулганууд хэвшмэл дэг, улиг болсон сэдэв, хязгаарлагдмал зочдын хүрээнд өрнөх болсныг цөөнгүй хүн хэлдэг. Ялангуяа, эдгээр чуулганы хоорондох зай ойртох тусам ач холбогдол нь буурч байна.

Тухайлбал, өнгөрсөн есдүгээр сард хөрөнгө оруулагчдын хоёр ч том чуулган зэрэг шахуу болсон. Тодруулбал, есдүгээр сарын 4-нд Frontier Securities байгууллагаас “Invest Mongolia” чуулган зохион байгуулсан бол үүнтэй залгаад “Discover Mongolia” эхэлсэн. Эдгээр чуулганы хамрах хүрээ, хэлэлцэх сэдвээс гадна хүрэлцэн ирсэн оролцогчид нь хүртэл давхцаж, давтагдаж байсан юм. Зарим албан тушаалтан бүр чуулганаас чуулганы хооронд ажиллаж буйгаа ч учирлаж байв. Тухайн үеийн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэхүү хий хоосон уулзалт, чуулганы тоо хэтэрснийг гярхай ажиглаж, “Invest Mongolia” чуулганд оролцох үеэрээ шүүмжилсэн. Тэрбээр “Монгол Улсад хөрөнгө оруулах зорилго бүхий нэг л чуулганыг бид янз бүрийн нэршил дор сүүлийн 10 гаруй жил зохион байгуулж ирлээ. Заримдаа жилд хоёр, гурваар нь хийлээ. Цаг зав, хөрөнгө мөнгөө зарцуулаад олон ч хөрөнгө оруулагч ирж байна. Гэвч эдгээр чуулганы бодитой үр дүн амьдралд тэр бүр харагдахгүй, үүнээс болж арга хэмжээ нь өөрөө үнэгүйдэх хандлагатай байгааг зохион байгуулагчид анхаарах хэрэгтэй” хэмээн хатуухан сануулаад амжсан юм.

Үүнийг хэлэхэд, сүржин нэртэй, тансаг танхимуудад болдог ийм арга хэмжээний өрнөл нь даан ч даржин. Өнөөх улиг болсон илтгэлүүд, урагшилдаггүй хэдэн төслөө

| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГАН | Сүүлийн нэг жилд |
|--|------------------|
| “INVEST MONGOLIA” ХОНКОНГ | 2016.10.31 |
| “INVEST MONGOLIA” ТОРОНТО | 2017.03.05 |
| “MONGOLIA GOLD 2017” | 2017.03.17 |
| PDAC КАНАД | 2017.03.05 |
| “INVEST MONGOLIA” УЛААНБААТАР | 2017.06.05 |
| УЛААНБААТАР | 2017.09.04 |
| DISCOVER MONGOLIA 2017 | 2017.09.07 |
| МОНГОЛ, ХЯТАДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМ | 2017.09.27 |
| “INVEST MONGOLIA” ТОКИО 2017 | 2017.11.24 |
| “МОНГОЛЫН ЭРДЭС БАЯЛАГ-УУЛ УУРХАЙ” | 2018.03.22 |
| “INVEST MONGOLIA” ХОНКОНГ | 2018.04.20 |



залхтал ярина. Удирдах түвшний албан тушаалтнууд хөрөнгө оруулагчдыг хамгаалж, өмгөөлнө хэмээн амлаж, чихэнд чимэгтэй үгс урсгасаар чуулганыг дуусгадаг. Дээрээс нь энэ үеэр хэрэг болох нь ховор. Хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн хэлсэн санал, гомдол төрийн бодлого, шийдвэр гаргалтад тусгах нь бага гэдгийг ч хувийн хэвшлийнхэн учирладаг. “Бид цуглаж суугаад ирээдүй цаг дээр олон жил ярилаа. Хөрөнгө оруулалтын ийм чуулганууд одоо хэлбэрийн хувьд дараагийн шатандаа орох хэрэгтэй. Ярьж чуулахаас илүүтэй, хамтарч хийж бүтээдэг бодитой хамтын ажиллагаа чухал байна” хэмээн Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбат чуулганы шүүмжлэлээ төгсгөж байсан юм. Үүнийг ч чуулганд оролцогчид хүлээн зөвшөөрч байсан. Тэд жилээс жилд нэмэгдэж буй хөрөнгө оруулалтын чуулганы тооны ард нуугдсан чанар, үр дүнг эргэн харж, нэхэн хэлэлцэх цаг болсныг сануулж байв. Дотоодод болдог чуулганууд ийм бүдгэр төрхтэй бол хилийн чанадынх ч нэг их дээрдэхгүй.

Хэдийгээр энэ чиглэлийн чуулганууд нь хувийн хэвшлийн санаачилгаар өрнөдөг ч төрийн зүгээс олон талаар хамтран ажиллаж, дэмждэг. Дэлхийн томоохон санхүү, эдийн засгийн төвүүдэд болж буй хөрөнгө оруулагчдын чуулганд оролцохоор Монголоос сайд дарга нараас бүрдсэн том хэмжээний баг явдаг. Гэвч тэд төсвийн мөнгөөр туулж, томиллолтоор явчихаад, эргээд

уриа лоозонгийн шинж чанартай зүйлийг ярьдаг. Монголчуудын ийм арчаагүй, үлбэгэр байдал нь хөрөнгө оруулагчдын сонирхол, Монголын үнэлэмжийг бууруулдаг байна. Ингээд гадаадад үнэтэй тансаг заал түрээсэлж, нүсэр хүлээн авалт хийсэн чуулганууд нь ядруухан үр дүн дагуулах нь ажиглагддаг. Ер нь Монголыг төлөөлөн, хилийн чанадад чуулга уулзалтад оролцохыг төрийн албан хаагчид төсвийн мөнгөөр зугаалж, амрах арга мэтээр ойлгох хандлага байдгийг шүүмжлэх нэгэн бий. Гэтэл монголчуудын бэлтгэл муу, сонирхолгүй, уйтгартай байдлаас залхсан гадаадын түншүүд Монголд хөрөнгө оруулагчдын чуулганы үеэр хоорондоо уулзаж, ажил хэрэг хэлэлцдэг гэх мэдээлэл ч байна.

Эцэст энэ нийтлэлээр хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, төр засаг нэгэн дээвэр дор чуулж, хэлэлцэх боломж олгодог хөрөнгө оруулагчдын чуулганыг бүрэн гүйцгэх гэсэнгүй. Энэ төрлийн чуулган нь Монгол Улсыг олон улсад таниулан, сурталчлах, эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Тэрчлэн олон улс дахь Монголын нэр хүнд, боломжийг гадаадын хөрөнгө оруулагчдад таниулахад хувийн хэвшлийн санаачилга өндөр байсныг дурдах нь зүйтэй. Ялангуяа, энэ чиглэлийн арга хэмжээнд идэвхийлэн оролцож, 10 гаруй жилийн турш хөрөнгө оруулагчдын чуулган зохион байгуулах ачааны хүндийг үүрч буй “Frontier Securities”, Монголын бизнесийн зөвлөл, Монгол дахь Америкийн худалдааны танхим зэрэг байгууллагуудыг орхиж болохгүй. Гол нь аливаа чуулган уулзалт олон болохын хэрээр чанар, ач холбогдол нь буурч, үр дүн нь багасдаг. Улмаар Монгол Улсыг улам бүдүүлэг, боловсрол дутмаг болгон харагдуулах хандлага байгааг шүүмжилж байгаа юм. Угтаа Монгол Улсыг олон улсад таниулаж, хөрөнгө оруулагчидтай ойлголцоо улам бататгах учиртай энэ төрлийн чуулган хөрөнгө оруулагчдыг залхааж, үргээх тал ажиглагдаж байна. [ЗГМ]

уриа лоозонгийн шинж чанартай зүйлийг ярьдаг. Монголчуудын ийм арчаагүй, үлбэгэр байдал нь хөрөнгө оруулагчдын сонирхол, Монголын үнэлэмжийг бууруулдаг байна. Ингээд гадаадад үнэтэй тансаг заал түрээсэлж, нүсэр хүлээн авалт хийсэн чуулганууд нь ядруухан үр дүн дагуулах нь ажиглагддаг. Ер нь Монголыг төлөөлөн, хилийн чанадад чуулга уулзалтад оролцохыг төрийн албан хаагчид төсвийн мөнгөөр зугаалж, амрах арга мэтээр ойлгох хандлага байдгийг шүүмжлэх нэгэн бий. Гэтэл монголчуудын бэлтгэл муу, сонирхолгүй, уйтгартай байдлаас залхсан гадаадын түншүүд Монголд хөрөнгө оруулагчдын чуулганы үеэр хоорондоо уулзаж, ажил хэрэг хэлэлцдэг гэх мэдээлэл ч байна.

Эцэст энэ нийтлэлээр хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, төр засаг нэгэн дээвэр дор чуулж, хэлэлцэх боломж олгодог хөрөнгө оруулагчдын чуулганыг бүрэн гүйцгэх гэсэнгүй. Энэ төрлийн чуулган нь Монгол Улсыг олон улсад таниулан, сурталчлах, эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Тэрчлэн олон улс дахь Монголын нэр хүнд, боломжийг гадаадын хөрөнгө оруулагчдад таниулахад хувийн хэвшлийн санаачилга өндөр байсныг дурдах нь зүйтэй. Ялангуяа, энэ чиглэлийн арга хэмжээнд идэвхийлэн оролцож, 10 гаруй жилийн турш хөрөнгө оруулагчдын чуулган зохион байгуулах ачааны хүндийг үүрч буй “Frontier Securities”, Монголын бизнесийн зөвлөл, Монгол дахь Америкийн худалдааны танхим зэрэг байгууллагуудыг орхиж болохгүй. Гол нь аливаа чуулган уулзалт олон болохын хэрээр чанар, ач холбогдол нь буурч, үр дүн нь багасдаг. Улмаар Монгол Улсыг улам бүдүүлэг, боловсрол дутмаг болгон харагдуулах хандлага байгааг шүүмжилж байгаа юм. Угтаа Монгол Улсыг олон улсад таниулаж, хөрөнгө оруулагчидтай ойлголцоо улам бататгах учиртай энэ төрлийн чуулган хөрөнгө оруулагчдыг залхааж, үргээх тал ажиглагдаж байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

188

Компани. Арилжаа эрхлэх байгууллагуудад бүртгэлтэй хувьцаат компаниудыг өмчийн хэлбэрээр нь авч үзэхэд, 219 хувьцаат компанийн 188 буюу 86 хувь нь хувийн өмчийн хэлбэртэй байна.

» УУЛ УУРХАЙ

310

Тусгай зөвшөөрөл. Улсын хэмжээнд давхардсан тоогоор 237 аж ахуйн нэгжид нийт 310 түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгожээ.

» СТАТИСТИК

3.6

Мянга. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3.6 мянга буюу 15.5 хувь нь хангайн бүсэд оршиж сууж байна.

» ТӨСӨВ

1.8

Их наяд төгрөг. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2018 оны эхний улиралд 1.8 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.4 хувиар өссөн байна.

» ГАДААД ХУДАЛДАА

2.6

Тэрбум ам.доллар. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2.6 тэрбум ам.доллараар хэмжигдэж байна.

» БИЗНЕС

56

Тэрбум ам.доллар. Samsung Electronics-ийн нэгдүгээр улирлын цэвэр ашиг компанийн дүнгээр 52 хувиар нэмэгдэж, 10.7 тэрбум ам.долларт хүрсэн байна. Мөн борлуулалтын орлого нь 20 хувиар өсөж, 56 тэрбум ам.долларт хүрчээ.

» АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 28 компанийн 787,182 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр зургаан компанийн хувьцааны ханш өсөж, 14 компанийнх буурсан бол найман компанийнх тогтвортой байв.

» ХӨРШ

6.5

Хувь. БНХАУ-ын эдийн засаг энэ онд бага зэрэг удааширч, 6.5 хувь болох төлөвтэй байна. Тус улсын хувьд эдийн засгаа дахин тэнцвэржүүлэх буюу хөрөнгө оруулалтаас илүү дотоодын хэрэглээг бодлогоор дэмжиж буй.

ВАЛЮТЫН ХАНШ

| | |
|---------------|----------|
| АНУ-ын доллар | 2,397.07 |
| Евро | 2,923.23 |
| Японы иен | 22.01 |
| ОХУ-ын рубль | 38.89 |
| БНХАУ-ын юань | 379.61 |
| БНСУ-ын вон | 2.22 |

ТАЙЛАН

Ипотекийн зээлд шинээр 49.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ

Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл өнгөрсөн сард 4.3 их наяд төгрөг болж, 0.3 хувиар өсчээ. Тайлант хугацаанд 497 иргэнд 49.5 тэрбум төгрөгийн зээл шинээр олгосон байна. Ингэснээр улсын хэмжээнд орон сууцны зээлтэй иргэдийн тоо 93099 болж нэмэгдлээ. Үүний 69.3 хувь нь хоёр сая хүртэлх төгрөгийн өрхийн

орлоготой байна. Салбарын яамны мэдээллээр, нийслэлд 80 орчим мянган айлын орон сууцны барилга угсралтын ажил үргэлжилж байгаагаас 30 мянга нь ашиглалтад оржээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 49.4 хувь буюу 2.5 их наяд төгрөгөөр 2011-2015 онд ашиглалтад орсон орон сууц худалдан авчээ. Нэг

зээлдэгчид дунджаар 78.3 сая төгрөг ногдож байна. Орон сууцны зээлийн 95.7 хувь нь хувийн байна. Монголбанк болон Засгийн газар хамтран 2013 оноос ипотекийн найман хувийн хүүтэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Засгийн газар болон Монголбанк өнгөрсөн онд ипотекийн зээлд 354 тэрбум төгрөг зарцуулсан.

ДЭЛХИЙД

БНСУ-ын ДНБ 1.1 хувиар өсөв

БНСУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн энэ оны эхний улиралд урьдчилсан дүнгээр 1.1 хувиар өсчээ. Өнгөрсөн оны IV улиралд эдийн засгийн өсөлт нь саараад байсан ч энэ оны эхний улиралд сард тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ийнхүү эргэн сэргэжээ. БНСУ-ын экспорт, компаниудын хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг нь дэмжсэн

гэж шинжээчид үзэж байна. Хэдийгээр экспортын салбар эргэн сэргэсэн ч ажил эрхлэлт, иргэдийн зарцуулалт буурсаар байгаа юм. Тоон үзүүлэлтээс харвал, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 5.2 хувиар, барилгын салбарын хөрөнгө оруулалт 2.8 хувиар, тус тус өссөн байна. БНСУ-ын төв банк энэ оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг гурван хувьд хүрнэ гэж таамаглаж байгаа юм.

Эдийн засаг

Уул уурхайн орлогын 59 хувийг зэс дангаараа бүрдүүлнэ

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Дэлхийн зах зээлийн өнгө төрхөөс таваарын үнэ нь хамаардаг, ашиг орлогыг нь ямагт эрдэс дагадаг салбар бол уул уурхай. Ялангуяа, аж үйлдвэрийн түүхий эдийн салбарт гол тоглогч болж чаддаггүй Монгол Улсын хувьд бусад орны улс төр, геополитикийн бодлогоос шалтгаалан эрдэс баялгийн үнэ, цаашлаад төсвийн орлого нь савлаж байдаг.

Тухайлбал, зэсийн үйлдвэрлэл гэхэд нийлүүлэлтийн доголдол, нөөц илрүүлэлт, БНХАУ болон БНЭУ-ын эдийн засгийн өсөлт, ам.долларын ханшны хэлбэлзэл зэргээс шалтгаалан үнэ нь өөрчлөгдөх магадлалтай. Мэргэжилтнүүд зэсийн үнэ 100 ам.доллараар буурахад төсөв 7.9 тэрбум төгрөг, борлуулалт нь 100 мянган тонноор буурахад 35.9 тэрбум төгрөгөөр төсвийн орлого тасарч болзошгүй гэж үзжээ. Харин нүүрсний тонн тутмын үнэ таван ам.доллараар буурахад төсөвт орох орлого нь 4.9 тэрбум төгрөгөөр багасах магадлалтай онцолсон. Мөн улс төр, геополитикийн асуудлаас шалтгаалж экспортын хэмжээ нь нэг сая тонноор буурвал 8.9 тэрбум төгрөгийн татвар буурах эрдэстэй гэж үзжээ.

Эрдэс баялгийн салбараас улсын төсөвт орох 1.7 их наяд төгрөгийн 806.4 тэрбум төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр эзэлж буй. Үүнээс улсын төсөвт дөрөвний нэгийг нь буюу 248.2 тэрбум төгрөгийг зарцуулна. Харин үлдсэнийг нь Төсвийн тогтворжуулалтын санд 97.4 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 460.9 тэрбум төгрөг төвлөрүүлэх зэргээр захиран зарцуулах юм.

2018 оны Төсвийн тухай хуулийг өнгөрсөн оны сүүлээр батлахдаа олон улсын шинжээчид, судалгааны байгууллагуудын таамгийг харгалзан эрдэс баялгаас улсын төсөвт орох орлогыг төлөвлөсөн. Үүнд, манай улс энэ онд хэр хэмжээтэй уул уурхайн бүтээгдэхүүн олборлож, хэдэн тонны орлого төвлөрүүлэхээр байгааг задалж харья.





Дэлхийн зэсийн хэрэглээ 2018 онд дунджаар 2.4 хувиар өснө гэж шинжээчид төсөөлж байна.



Салбарын өсөлт 2018 онд 3.9, 2019 онд 8.1, 2020 онд 13.8 хувьд тус тус хүрнэ гэж шинжээчид таамаглажээ.

С.Батсайхан / ЗГМӨ

Эрдсийн салбарын эмзэг байдал төсвийн бодит эрсдэл



зэсийн баяжмалд 8.8 тонн алт агуулагдана гэж шинжээчид үзжээ. Олон улсын шинжээчдийн таамагт үндэслэн 2018 онд нэг унци алт 1291 ам.доллар байхаар төсөвт тусгасан юм.

Хил гарган худалдаж буй эрдэс баялгийн гуравны нэгийг нүүрс эзэлдэг. Өнгөрсөн онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээндээ хүрч, улсын төсвийг хагас их наяд орчим төгрөгөөр зузаатгасан. 2017 онд манай улс 47.5 сая тонн нүүрс олборлож, 33.3 сая тонныг хилээс гадагш борлуулсан. Харин энэ онд 37.4 сая тонн нүүрс борлуулахаас 28 сая тонныг экспортлохоор ажиллаж байгаа юм. Үлдсэн 9.4 сая тонноор дотоодын нүүрсний хэрэгцээг хангах аж. Өөрөөр хэлбэл энэ онд нүүрсний экспортыг өнгөрсөн оныхоос 5.3 сая тонноор бууруулан тооцжээ. Үүнээс үзвэл нүүрсний салбар 2018 оны улсын төсөвт нийт 495.5 тэрбум төгрөгийн орлого оруулахаар байна. Ирэх оны төсөвт баяжуулсан коксжих нүүрсний үнийг тонн тутам 100 ам.доллар, боловсруулаагүй коксжих нүүрсний үнийг 60 ам.доллар байхаар тусгажээ.

Шинжээчид оны эхэнд нүүрсний салбарыг тийм ч өөдрөгөөр төсөөлж байгаагүй. БНХАУ-ын гангийн хэрэглээ буурч буй, Гашуун сухайтын боомтын нэвтрүүлэх чадвар багассан зэргийг экспортын хэмжээ болон үнэ ханштай нь уялдуулан таамаглаж байсан юм. Харин энэ сард Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНХАУ-д хийсэн айлчлалын үр дүн энэ салбарт багагүй эерэг нөлөө авчирч, борлуулалтын орлогыг өсгөх магадлалтай байгаа юм.

2018 онд нэг баррель газрын тосны үнэ 50 ам.доллараас доошгүй байна гэж төсөөлж, экспортод 8.1 сая баррелийг гаргахаар төлөвлөсөн. Энэ нь улсын төсөвт 223.4 тэрбум төгрөг оруулах аж. Мөн цайр, төмрийн хүдэр болон бусад түүхий эдүүд 136.9 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээр байгаа юм.

Энэ бол өнгөрсөн оны аравдугаар сарын байдлаарх 2018 оны эрдсийн салбарын төсөөлөл. Он гарсаар уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ханш үүнээс буураагүй ч гадна, дотнын олон хүчин зүйл, үйл явдлаас шалтгаалсан эрсдэл биднийг дагасаар байна. [ЗГМ]

Монгол Улс төсвийн орлого бүрдүүлэхдээ уул уурхайн бүтээгдэхүүн, ялангуяа зэсийн үйлдвэрлэлд найдлага тавьдаг. 2017 онд төсвийн орлогын 19 хувийг эрдэс баялгийн салбар бүрдүүлсэн бол тус салбарын 59 хувийг зэс эзэлж байгаа нь хэр чухал түүхий эд гэдгийг нь бэлхэн харуулна. Үүний дараа алт, нүүрс зэрэг эрдсүүд төсөв дэх байр сууриараа эрэмбэлэгдэж буй.

Монгол Улс энэ онд төсөвт нийт 7.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцсон. Харин уул уурхайн салбараас 1.7 их наяд төгрөг олохоор төлөвлөдөг байна. Энэ нь 2017 оныхоос 300 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм. 2018 онд дэлхийн зах зээл дээрх таваарын үнэ харьцангуй тогтвортой, дунд хугацаанд улсын эдийн засаг сэргэхээр байгаа зэргийг тооцсон нь энэ. Үүнээс гадна уул уурхайн цөөнгүй томоохон төслүүдийн бүтээн байгуулалт ойрын хоёр жилд хэрэгжиж эхлэхээр байгаа. Ингэснээр уул уурхайн салбарын өсөлт 2018 онд 3.9, 2019 онд 8.1,

2020 онд 13.8 хувьд тус тус хүрнэ гэж шинжээчид таамаглаж буй. Манай улсын уул уурхайн салбар сэргэх нь үйлдвэр, үйлчилгээ зэрэг бусад салбарт багагүй нөлөөлдөг онцлогтой. Тиймд уул уурхайн бус салбарын ДНБ-ий хэмжээ энэ онд 4.3, 2019 онд 5.3, 2020 онд 1.8 хувиар өсөхөөр байгаа аж.

Уул уурхайн үйлдвэрлэл төсөвт 1.7 их наяд төгрөг төвлөрүүлнэ

Өнгөрсөн таван жилд уул уурхайн салбарын орлого улсын төсвийн 19 орчим хувийг эзэлж байсан. Харин энэ онд байр сууриа ахиулж 22 хувьд хүрэхээр байгаа юм.

Дээр дурдсанчлан зэс, зэсийн баяжмал салбарынхаа төсвийн

60 орчим хувийг буюу нэг их наяд төгрөгийг бүрдүүлнэ. Зэсийн бүтээгдэхүүний гол экспортлогч “Эрдэнэт” үйлдвэр, “Оюутолгой”-н үйлдвэрлэл энэ оны эцэст 2017 оныхтой дүйцэхүйц хэмжээнд очихоор байна. “Оюутолгой” компани 2018 онд 764.8 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж 406.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт оруулахаар байгаа. Харин “Эрдэнэт” үйлдвэр 601.2 мянган тонн зэсийн баяжмал, 4.1 мянган тонн молибдены баяжмал экспортолж, 538.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх юм байна. Түүнчлэн зэсийн үүсмэл ордод үйл ажиллагаа явуулдаг бусад компаниуд 62.6 тэрбум төгрөгийн татвар төсөвт оруулахаар байгаа юм. Улсын төсөвт уг түүхий эдийн дэлхийн зах зээлийн тонн тутмын үнэ 6430 ам.доллар байхаар тооцжээ.

Тэгвэл алтны үйлдвэрлэлээс 80.4 тэрбум төгрөг улсын төсөвт нэмэгдэхээр байна. Өнгөрсөн онд “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд дотоодын алт тушаалт нэмэгдсэн. Тодруулбал, 2017 онд 18 тонн

алт авна гэж Монголбанкнаас таамаглаж байсан ч оны эцэст 20 тонн болж, төлөвлөгөө давж биелсэн.

● **“Оюутолгой” компани 2018 онд 764.8 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж 406.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт оруулахаар байна.**

● **Энэ онд нүүрсний экспортыг өнгөрсөн оныхоос 5.3 сая тонноор бууруулан тооцжээ.**

● **Мэргэжилтнүүд зэсийн үнэ 100 ам.доллараар буурахад 7.9 тэрбум төгрөгөөр төсвийн орлого тасарч болзошгүйг онцоллоо.**

Харин энэ онд 21 тонн алт Монголбанкинд тушаана гэж төлөвлөдөг байгаа юм. Түүнчлэн “Оюутолгой”-н экспортын

УУЛ УУРХАЙН САЛБАРААС ОРОХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | |
|--|--|
| БИЕТ ХЭМЖЭЭ | ОРЛОГО (тэрбум төгрөг) |
| Алт (тонн), дотоодын | 21 ◆ 80.4 |
| Нүүрс (сая.тн) | Экспортын нүүрс 28 сая.тн, дотоодын нүүрс 9.4 сая.тн |
| 37.4 ◆ 495.5 | |
| Зэсийн баяжмал (мян.тн) дагалдах эрдсүүд (Оюу Толгой ХХК-ийн баяжмалд агуулагдах алт орсон) | 1,366 ◆ 1,007.1 |
| Цайрын баяжмал (мян.тн) | 106.6 ◆ 42.6 |
| Төмрийн хүдэр (сая.тн) | 7.5 ◆ 56.5 |

Сангийн яам ©

| DOW JONES | S&P 500 | FTSE 100 | NIKKEI 225 | TOPIX | SHANGHAI COMPOSITE | HANG SENG | KOSPI |
|-----------|---------|----------|------------|-------|--------------------|-----------|-------|
| 0.25% | 0.18% | 0.14% | 0.47% | 0.25% | 1.38% | 1.06% | 1.10% |